



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ-2014

(Өрхийн нийгэм, эдийн засгийн 2014 оны
судалгааны үр дүн)

Улаанбаатар 2015

Үндэсний статистикийн хороо
Засгийн газрын III байр
Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар
Монгол Улс
И-мэйл: information@nso.mn
Факс: 976-11-324518
Утас: 326414, 262424

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргав.
Улаанбаатар хот, Монгол Улс, 2015 он

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	7
ӨМНӨХ ҮГ	8
1. ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДАЛ	9
1.1 Ядуурлын хэмжүүр	10
1.2 Ядуурлын шугамын түвшний мэдрэмж	10
1.3 Ядуурлын газар зүйн тархалт	12
1.4 Ядуурлын чиг хандлага	14
1.5 Цаг хугацааны харьцуулалт ядуурлын шугамын түвшнээс хамаарах нь	16
1.6 Тэгш бус байдал	17
1.7 Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь	19
2. АЖ БАЙДЛЫН ДҮР ТӨРХ	21
2.1 Хэрэглээний хэв шинж	22
2.2 Ядуурал улирлын хэлбэлзлээс хамаарах нь	25
2.3 Өрхийн ам бүлийн бүтэц	25
2.4 Өрхийн тэргүүлэгчийн шинж байдал	27
2.4.1 Нас	28
2.4.2 Хүйс	28
2.4.3 Боловсрол	29
2.4.4 Ажил эрхлэлт	31
2.5 Хөрөнгө	34
2.5.1 Мал	34
2.5.2 Газар	37
2.5.3 Хадгаламж	38
2.5.4 Зээл	39
2.6 Сууц	40
2.6.1 Сууцны төрөл	40
2.6.2 Дэд бүтцийн үйлчилгээ	42
2.7 Нийгмийн хамгаалал	46
2.7.1 Мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламжийн хэмжээ, түүний ач холбогдол	46
2.7.2 Өрхийн хүлээн авч байгаа мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж	48
2.7.3 Өндөр насны тэтгэвэр	49
ХАВСРАЛТ А. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2014 оны судалгаа	51
А.1 ӨНЭЗС-ны талаарх товч танилцуулга	52
А.2 Түүвэрлэлтийн зохиомж	52
А.3 Мэдээллийн чанар, боловсруулалт	53
ХАВСРАЛТ Б. Ядуурлын дүн шинжилгээний арга зүй	55
Б.1 Аж байдлын үзүүлэлтийн сонголт	56
Б.2 Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоох нь	57
Б.3 Үнийн засварлалт	63
Б.4 Өрхийн бүтцийн засварлалт	64
Б.5 Ядуурлын шугам	66
Б.6 Ядуурлын хэмжүүрүүд	69
ХАВСРАЛТ В. Доод, дээд ядуурлын тооцоонууд	75
ХАВСРАЛТ Г. Статистикийн хүснэгт	79
ХАВСРАЛТ Д. Ядуурлын тооцоонуудын стандарт алдаа ба итгэмжлэлт интервалууд	133

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1.1. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дунджаар	10
1.2. Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд	11
1.3. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр	12
1.4. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар	13
1.5. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2012, 2014 он	15
1.6. Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ 2012, 2014 он	17
1.7. Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь 2012, 2014 он	20
2.1. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, төгрөгөөр	23
2.2. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, ядуурлын байдлаар, хот, хөдөөгөөр	24
2.3. Ядуурал ба өрхийн ам бүлийн тоо	26
2.4. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар	27
2.5. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр	28
2.6. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр	30
2.7. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар	32
2.8. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн салбараар	33
2.9. Мал аж ахуй эрхлэлт	35
2.10. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар	36
2.11. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, газар өмчлөлийн байдлаар	37
2.12. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламжийн байдлаар	38
2.13. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, зээлийн төрлөөр	39
2.14. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр	41
2.15. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр	43
2.16. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр, хот, хөдөөгөөр	45
2.17. Өрхийн хүлээн авсан шилжүүлэг, бэлэг, тусламж	47
2.18. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын болон хувийн шилжүүлэг, бэлэг тусламжаар	48
2.19. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өндөр насны тэтгэвэр	49
А.1. 2014 оны ӨНЭЗС-ны түүвэр, ТАШН-ээр, ярилцлага авсан сараар	53
Б.1. Түүврийн анхан шатны нэгжийн Паашийн индекс, бүлгээр, ярилцлага авсан сараар	64
Б.2. Нэг хүнд хоногт ногдох хүнсний сагс, хүнсний гол нэрийн бүлгээр	67
Б.3. Нэг хүнд сард ногдох ядуурлын шугам	69
Б.4. Нэг хүнд ногдох хоногийн хүнсний сагс	71
В.1. Ядуурлын шугам 2012, 2014 он	76
В.2. Доод ядуурлын тооцоонууд 2012, 2014 он	76
В.3. Дээд ядуурлын тооцоонууд 2012, 2014 он	77
Г.1. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, ядуурлын байдлаар, суурьшлаар	80

Г.2. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, ядуурлын байдлаар, бүсээр	81
Г.3. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, төгрөгөөр, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр	82
Г.4. Нийт хэрэглээнд эзлэх хувь, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр	83
Г.5. Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, хот, хөдөөгөөр (хувиар)	86
Г.6. Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, суурьшлаар (хувиар)	87
Г.7. Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, бүсээр (хувиар)	88
Г.8. Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, хот, хөдөөгөөр (хувиар)	89
Г.9. Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, суурьшлаар (хувиар)	90
Г.10. Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, бүсээр (хувиар)	91
Г.11. Насанд хүрэгсдийн боловсролын дээд түвшин (хувиар)	92
Г.12. Насанд хүрэгсдийн боловсролын дээд түвшин, ядуурлын байдлаар (хувиар)	93
Г.13. Насанд хүрсэн хүн ам, боловсролын дээд түвшингээр (хувиар)	94
Г.14. Насанд хүрсэн хүн ам, боловсролын дээд түвшингээр болон ядуурлын байдлаар (хувиар)	95
Г.15. Бага, бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролын сургуульд хамрагдалтын түвшин (хувиар)	96
Г.16. Суралцагчдын боловсролын түвшин (хувиар)	98
Г.17. Суралцагчдын боловсролын түвшин, ядуурлын байдлаар (хувиар)	99
Г.18. Суралцагчдын шинж байдал, сурч буй боловсролын түвшингээр (хувиар)	100
Г.19. Суралцагчдын шинж байдал, сурч буй боловсролын түвшингээр болон ядуурлын байдлаар (хувиар)	101
Г.20. Улсын сургуульд суралцагчдын хувийн жин, боловсролын түвшингээр (хувиар)	102
Г.21. Улсын сургуульд суралцагчдын хувийн жин, боловсролын түвшингээр, ядуурлын байдлаар (хувиар)	103
Г.22. Улсын сургуулийн бага ангийн нэг суралцагчид ногдох зардал (нэг сард, төгрөгөөр)	104
Г.23. Улсын сургуулийн бага ангийн нэг суралцагчид ногдох зардал, ядуурлын байдлаар (нэг сард, төгрөгөөр)	105
Г.24. Бүрэн бус дунд боловсролын улсын сургуульд суралцагч, нэг хүнд ногдох зардал (нэг сард, төгрөгөөр)	106
Г.25. Бүрэн бус дунд боловсролын улсын сургуульд суралцагч, нэг хүнд ногдох зардал, ядуурлын байдлаар (нэг сард, төгрөгөөр)	107
Г.26. Улсын сургуулийн ахлах ангийн нэг сурагчид ногдох зардал (нэг сард, төгрөгөөр)	108
Г.27. Улсын сургуулийн ахлах ангийн нэг сурагчид ногдох зардал, ядуурлын байдлаар (нэг сард, төгрөгөөр)	109
Г.28. Хүн амын өвчлөл ба гэмтэл (хувиар)	110
Г.29. Хүн амын өвчлөл ба гэмтэл, хот, хөдөөгөөр, ядуурлын байдлаар (хувиар)	111

Г.30. Хүн амын өвчлөл ба гэмтэл, суурьшлаар, ядуурлын байдлаар (хувиар) ..	112
Г.31. Хүн амын өвчлөл ба гэмтэл, бүсээр, ядуурлын байдлаар (хувиар)	113
Г.32. Хүн амын өвчлөл ба гэмтэл, хүйсээр, ядуурлын байдлаар (хувиар)	114
Г.33. Хөгжлийн бэрхшээл (хувиар)	115
Г.34. Хөгжлийн бэрхшээл, хот, хөдөөгөөр, ядуурлын байдлаар (хувиар)	115
Г.35. Хөгжлийн бэрхшээл, суурьшлаар, ядуурлын байдлаар (хувиар)	116
Г.36. Хөгжлийн бэрхшээл, бүсээр, ядуурлын байдлаар (хувиар)	116
Г.37. Хөгжлийн бэрхшээлийн тохиолдол, хүйсээр, ядуурлын байдлаар (хувиар)	117
Г.38. Нэг хүнд сард ногдох эрүүл мэндийн зардал (төгрөгөөр)	118
Г.39. Нэг хүнд сард ногдох эрүүл мэндийн зардал, ядуурлын байдлаар (төгрөгөөр)	119
Г.40. Хүн амын тархалт, ажиллах хүчний байдлаар	120
Г.41. Хүн амын тархалт, ажиллах хүчний байдлаар, ядуурлын байдлаар	121
Г.42. Ажиллах хүчний оролцооны түвшин ба ажилгүйдлийн түвшин, ядуурлын байдлаар	122
Г.43. Ажиллах хүчний оролцооны түвшин ба ажилгүйдлийн түвшин, хүйсээр	123
Г.44. Хүн амын ажил эрхлэлт, салбараар, мэргэжлээр, ядуурлын байдлаар (хувиар)	124
Г.45. Хүн амын ажил эрхлэлт, салбараар, мэргэжлээр, хүйсээр (хувиар)	125
Г.46. Ядуурлын дүр төрх, хадгаламж, зээлийн байдлаар, хот, хөдөөгөөр (хувиар)	126
Г.47. Ядуурлын дүр төрх, хадгаламж, зээлийн байдлаар, суурьшлаар (хувиар)	127
Г.48. Ядуурлын дүр төрх, хадгаламж, зээлийн байдлаар, бүсээр (хувиар)	128
Г.49. Сүүлийн 12 сард авсан зээлийн хэмжээ, төрлөөр (мян.төгрөгөөр)	129
Г.50. Зээлийн зарцуулалт, зориулалтаар (хувиар)	130
Г.51. Зээлийн зарцуулалт, зориулалтаар, ядуурлын байдлаар (хувиар)	131
Г.52. Удаан эдэлгээт бараа	132
Д.1. Ядуурлын байдал, хот, хөдөөгөөр	134
Д.2. Ядуурлын байдал, суурьшлаар	135
Д.3. Ядуурлын байдал, бүсээр	136
Д.4. Ядуурлын байдал, судалгааны улирлаар	137
Д.5. Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн насаар	138
Д.6. Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр	139
Д.7. Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшнээр	140
Д.8. Ядуурал ба мал аж ахуй	141
Д.9. Ядуурлын байдал, хадгаламжийн байдлаар	142
Д.10. Ядуурал ба зээл	143
Д.11. Ядуурлын байдал, сууцны төрлөөр	144
Д.12. Ядуурал ба сайжруулсан усан хангамж	145
Д.13. Ядуурал ба сайжруулсан ариун цэврийн байгууламж	146
Д.14. Ядуурал ба цахилгаан эрчим хүчний хангамж	147
Д.15. Ядуурал ба сайжруулсан усан хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламж	148

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1.1 Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт	10
1.2 Нэг хүнд ногдох хэрэглээний нягтралын функц	11
1.3 Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд сард ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт	14
1.4 Нэг хүнд сард ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт 2012, 2014 он	16
1.5 Нэг хүнд сард ногдох хэрэглээ: Лоренцын муруй	18
1.6 Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 5 бүлгээр	18
1.7 Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 10 бүлгээр, хот хөдөөгөөр	18
2.1 Ядуурлын хамралтын хувь, улирлаар.....	25
2.2 Ядуурал ба хүн ам зүйн ачааллын харьцаа	27
2.3 Ядуурал ба малын тоо	36
2.4 Дэд бүтцийн үйлчилгээний хүртээмж, ядуурлын байдлаар	44
Г.1. Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, хот, хөдөөгөөр, 2012, 2014 он	84
Г.2. Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, суурьшлаар, 2012, 2014 он	85
Г.3. Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, бүс нутгаар, 2012, 2014 он	85
Г.4. Сургуульд хамрагдалтын түвшин	97

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ӨНЭЭС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ТАШН	Түүвэрлэлтийн анхан шатны нэгж
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАНСГ	Хүн ам, нийгмийн статистикийн газар
GE	Ерөнхий Энтропи

ӨМНӨХ ҮГ

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын талаарх тоо мэдээллийг тооцон тодорхойлсоор ирсэн. ҮСХ-ноос тогтмол зохион байгуулан явуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд 2014 онд хамрагдсан 16 мянга гаруй өрхийн мэдээлэлд үндэслэн ядуурлын өнөөгийн түвшин, ядуурлын хамралтад гарч буй өөрчлөлтийн талаар шинжилгээ хийж энэ тайланг бэлтгэн гаргаж байна. Энэхүү түүвэр судалгаа нь үндэсний хэмжээний томоохон судалгаануудын нэг бөгөөд мэдээллийн хэрэгцээ, давтамж зэргээс шалтгаалан хураангуй болон дэлгэрэнгүй гэсэн хоёр хэлбэртэйгээр хийгдэж байна. Тэгш тоотой жилүүдэд буюу хоёр жил тутам хүн амын аж байдал, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох зорилгоор судалгааны асуулгыг амьжиргааг тодорхойлох үзүүлэлтүүдээр баяжуулан явуулж үр дүнг гаргаж байна.

ҮСХ нь ядуурлын талаарх бодитой тоо, мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцох чиглэлээр Дэлхийн Банкны мэргэжилтнүүдтэй удаан хугацааны туршид хамтран ажилласаар ирсэн. Энэ урт хугацааны хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшний өөрчлөлтийг бодитойгоор харуулж чадахуйц, олон улсын стандарт шаардлагад нийцсэн аргачлалыг боловсруулан тооцоогоо хийсээр ирлээ.

Энэхүү судалгааны тоо мэдээлэл, үр дүнгийн тайлан нь зөвхөн төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт төдийгүй ядуурал, нийгэм, эдийн засгийн асуудлыг судалдаг эрдэмтэд болон сонирхсон хэн бүхэнд хамгийн сүүлийн үеийн бодит мэдээлэл, гарын авлага болно гэдэгт итгэлтэй байна.

Судалгааны үр дүнг боловсруулах бүхий л шатанд хамтран ажиллаж эцсийн үр дүнг хамтарч зарласан Дэлхийн Банкны ядуурлын судалгааны мэргэжилтнүүд болон Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын хамт олонд талархал илэрхийлье. Мөн судалгааг амжилттай зохион байгуулж, мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээг олон улсын арга зүйн дагуу гүйцэтгэж, судалгааны үр дүнгийн тайланг гаргасан ҮСХ-ны ХАНСГ-ын ӨНЭЗС-ны баг, мэдээллийг өрхөөс цуглуулах амаргүй ажлыг хийж гүйцэтгэсэн судлаачдад талархал илэрхийлье.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



С.МЭНДСАЙХАН

1.

ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДАЛ

Энэ бүлэг нь дараах гурван зорилгыг агуулж байна. Нэгдүгээрт, ядуурлын өнөөгийн цар хэмжээг тодорхойлж тэр нь ядуурлын шугамын түвшнээс хэрхэн хамаарч байгааг үнэлнэ. Хоёрдугаарт, тэгш бус байдлын чиг хандлагыг тодорхойлно. Гуравдугаарт, ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдээр авч үзнэ. Энэ удаагийн дүн шинжилгээнд хүн амын амьжиргааны түвшин, ядуурлыг тодорхойлохдоо өмнөх судалгаануудын адилаар мөнгөөрилэрхийлэгдэх үзүүлэлтээр буюу хүн амын хэрэглээнд үндэслэн тооцох арга зүйг баримталсан. Ядуурлын шугам нь хүн амын ядуу эсэхийг тодорхойлох босго үзүүлэлт бөгөөд нэг хүнд ногдох хэрэглээ нь ядуурлын шугамаас доогуур байвал тэр хүнийг ядуу гэж тодорхойлдог. Хүн амын хэрэглээнд үндэслэн гаргасан 2010 оны ядуурлын шугамыг үнийн индексээр индексжүүлэн 2014 оны ядуурлын шугамыг тооцоход 146.7 мянган төгрөг болж байна.

1.1 Ядуурлын хэмжүүр

Монгол Улсад ядуурлын түвшин буюу ядуурлын хамралтын хүрээ 2014 оны байдлаар 21.6 хувь (Хүснэгт 1.1) болсон бөгөөд 634.0 мянга орчим хүн ядууралд өртсөн байна. Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын 22 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна. Хэдийгээр ядуурлын түвшинг илэрхийлж байгаа энэ үзүүлэлтийн агуулгыг ойлгоход хялбархан боловч уг үзүүлэлт ядуучуудад үндсэн хэрэгцээгээ хангахад юу (мөнгөн дүнгээр) дутагдалтай байгаа, эсвэл ядуучуудын дунд хэрэглээ нь хэрхэн хуваарилагдсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгдөггүй нь бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд ноцтой сул тал болох магадлалтай. Жишээлбэл, тодорхой нэгэн бодлогыг хэрэгжүүлснээр ядуу хүн амын аж байдал дээшлэх боловч ядуурлын хамралтын хүрээ өөрчлөгдөхгүй үлдэж болно. Ядуурлын хамралтын хүрээ хэмээх үзүүлэлтийн сул талыг нөхөж ядуурлын талаар илүү тодорхой ойлголт авахын тулд ядуурлын гүнзгийрэлт ба мэдрэмж хэмээх өөр хоёр хэмжүүрийг ашигладаг.

Хүснэгт 1.1. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дунджаар

Хамралтын хүрээ	Ядуурлын гүнзгийрэлт	Ядуурлын мэдрэмж
21.6	5.2	1.9
(0.7)	(0.2)	(0.1)

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

Ядуурлын гүнзгийрэлт нь хүн амын хэрэглээ ядуурлын шугамаас хэр доогуур байгааг тодорхойлдог ядуурлын хамралтын хүрээнээс давуу талтай. Энэ үзүүлэлт 5.2 хувьтай байгаа нь ядуу хүн ам дунджаар ядуурлын


шугамаас 5.2 хувиар доош хэрэглээтэй байна гэсэн үг юм.

Ядуурлын мэдрэмж 1.9 хувь байна. Энэ хэмжүүрийн ядуурлын хамралтын хүрээ болон гүнзгийрэлтээс ялгаатай нь ядуучуудын хэрэглээний тархалтаас хамаардаг. Жишээлбэл, нэг ядуу өрхийн хэрэглээ багасч харин тэр өрхөөс арай өөр өрхийн хэрэглээ яг тэр хэмжээгээр ихэссэн ч ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хэвээрээ байвал ядуурлын хамралтын хүрээ болон ядуурлын гүнзгийрэлт өөрчлөгдөхгүй боловч ядуурлын мэдрэмж нь нэмэгдэнэ. Энэ үзүүлэлтийг ядуурлын хамралтын хүрээ болон гүнзгийрэлт нь ижил байгаа бүлгүүдийн ядуурлыг харьцуулахад ашигладаг.

1.2 Ядуурлын шугамын түвшний мэдрэмж

Ядуурлын шугамын түвшин өөрчлөгдөхөд ядуурлын хэмжүүрүүд хэр зэрэг мэдрэмжтэй байгааг тодорхойлох нь ядуурлыг бүрэн ойлгоход зайлшгүй чухал. Ядуурлын шугамыг өсгөх юмуу бууруулахад ядуурлын хамралтын хүрээ хэр зэрэг өөрчлөгдөхийг тооцоолохын тулд нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалтын функцийг зураг дээр дүрсэлж харуулав.

Зураг 1.1. Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт




Хэрэглээг хэвтээ тэнхлэг, хэрэглээний тухайн түвшинд харгалзах хүн амын тооны өсөн нэмэгдэх хувь хэмжээг босоо тэнхлэгээр илэрхийллээ. Хэрэглээний ямар нэг түвшинг сонгоод ядуурлын түвшин гэж үзэх юм бол уг шугамаар тодорхойлогдох ядуурлын хамралтын хүрээний түвшинг энэ муруй илэрхийлэх учир үүнийг “Ядуурлын хамралтын хүрээний муруй” гэж үзэж болох юм. Нэг хүний сарын хэрэглээний хэмжээ 146 648 төгрөгийг ядуурлын шугам гэж үзвэл нийт хүн амын 21.6 хувь нь ядуу байна. Дээрх түвшний орчимд тархалтын муруй эгц байгаа нь ядуурлын энэ шугамыг бага зэрэг өөрчлөхөд л ядуурлын хамралтын хүрээ нэлээн хэмжээгээр өөрчлөгдөх магадлалтайг харуулж байна. Эндээс ядуу бус хүн амын дотор ядуурлын шугамд ойр хэрэглээтэй хүмүүс нэлээд хувийг эзэлж байна гэж харж болохоор байна.

Ядуурлын шугамын ойролцоо байгаа өрхүүдийн төвлөрлийг нягтралын функц хэмээх өөр нэгэн ойлголт ашиглан тайлбарлая.¹ Зураг 1.2-т нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр тооцсон нягтралыг дүрслэн харууллаа. Эндээс ядуурлын шугамын ойролцоо байгаа тархалтын 2 чухал онцлог шинж харагдаж байна. Үүнд: Нэгдүгээрт, ядуурлын шугамын ойролцоо их хэмжээний төвлөрөл байна. Хоёрдугаарт, хүн амын дийлэнхийн хэрэглээний түвшин нь ядуурлын шугамнаас доош байх магадлал их байгаа нь ядуурлын

шугамыг нэмэгдүүлэх тохиолдолд ядуурлын хэмжүүрүүдэд гарч байгаа өөрчлөлтийн хэмжээ нь тухайн шугамыг бууруулахад гарах өөрчлөлтөөс бага байгааг харуулж байна.

Зураг 1.2 Нэг хүнд ногдох хэрэглээний нягтралын функц



Ядуурлын шугамыг өсгөж, бууруулж авсан ядуурлын 3 хэмжүүрийн тооцоог Хүснэгт 1.2-оос харж болно. Тухайлбал, ядуурлын шугамыг 10 хувиар нэмэгдүүлж мөн хэмжээгээр бууруулсан интервалын хооронд хүн амын 11.2 хувь нь оршиж байхад, ядуурлын шугамыг 20 хувиар өсгөж, бууруулсан интервалын хооронд хүн амын 21.2 хувь нь ногдож байна. Ядуурлын шугамыг 30 хувиар

Хүснэгт 1.2. Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд

Ядуурлын шугамыг хувилсанаар	Ядуурлын		
	Хамралтын хүрээ	Гүнзгий-рэлт	Мэдрэмж
150	49.3	15.4	6.6
140	44.0	13.1	5.5
130	38.5	11.0	4.4
120	32.8	8.9	3.5
110	27.2	7.0	2.6
100	21.6	5.2	1.9
90	16.2	3.7	1.3
80	11.6	2.5	0.8
70	7.5	1.5	0.5
60	4.1	0.8	0.2
50	2.0	0.3	0.1

Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

1. Нягтралын функцийг ойлголт нь ерөнхийдөө гистограммын ойлголттой ойролцоо. Энгийн гистограммууд сонгож авсан үзүүлэлтүүдийг тэнцүү урттай хэд хэдэн завсарт хуваан завсар бүрт харгалзах давтамжтай нь тэнцүү өндөртэй босоо тэгш өнцөгтүүдийг байгуулна. Нягтралын функцыг “тэгшитгэсэн” гистограмм гэж үзэж болох юм. Энэ нь нягтрал буюу харгалзах давтамжийг завсар бүр дээр биш цэг бүр дээр тооцдог. Тиймээс хэрэглээний хувьд үзвэл хэрэглээний түвшин бүрийн хоорондох зай бол тэр завсарт байгаа хүн амын хувь юм. (муруйгаас доош байгаа нийт зайг хүн амын 1 буюу 100 хувь гэж үзнэ.)

өсгөхөд буюу ядуурлын шугам 190,645 төгрөг байхад ядуурлын хамралтын хүрээ 38.5 хувь, ядуурлын шугамыг 30 хувиар бууруулахад буюу 102,655 төгрөг байхад ядуурлын хамралтын хүрээ 7.5 хувь болж байна. Нөгөө талаас ядуурлын шугам өсөхөд гарч байгаа ядуурлын хамралтын хүрээний өөрчлөлт нь ядуурлын шугам буурахад гарч байгаа өөрчлөлтөөс бага зэрэг өндөр байна.

1.3 Ядуурлын газар зүйн тархалт

Улс орны хэмжээнд ядуурал хэрхэн тархсан байна вэ? Энэхүү тайланд Монгол Улсыг газар зүйн хувьд бүс нутгаар, хот ба хөдөөгөөр,

суурьшлаар авч үзлээ. Засгийн газраас бүс нутгуудын эдийн засгийн хөгжлийг хурдасгах оновчтой бодлого боловсруулан хэрэгжүүлэх зорилгоор улс орноо эдийн засгийн таван бүс болгон авч үздэг. Хүснэгт 1.3-т ядуурлын үзүүлэлтүүдийг Баруун, Хангайн, Төвийн, Зүүн болон Улаанбаатар гэсэн таван бүс нутгаар харуулав.² Нийслэл хот болон Төвийн бүсэд ядуурал хамгийн бага буюу нийт хүн амынх нь 16.4-22.2 хувь нь ядуу байна. Баруун, Хангай болон Зүүн бүсэд ядуурлын хамралтын хүрээ хамгийн өндөр буюу нийт хүн амынх нь 25.3-31.4 хувь нь ядуу байна. Ядуу хүмүүсийн тархалтыг судалж үзэхэд Баруун бүсэд хүн амын 12.8 хувь оршин

Хүснэгт 1.3. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	26.0 (1.2)	25.3 (1.4)	22.2 (1.3)	31.4 (1.8)	16.4 (1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	5.3 (0.3)	5.4 (0.4)	5.5 (0.5)	8.6 (0.6)	4.5 (0.4)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	1.7 (0.1)	1.7 (0.1)	2.1 (0.2)	3.3 (0.3)	1.7 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувь (%)	100.0	12.8	19.4	16.2	6.9	44.7
Хүн ам (мян.хүн)	2937.9	376.7	567.4	475.9	203.4	1314.5
Нийт ядуучууд (%)	100.0	18.2	22.2	16.2	10.8	32.6
Ядуучууд (мян.хүн)	634.0	115.4	141.0	102.9	68.3	206.4
Өрхийн ам бүлийн тоо	3.5	4.0	3.4	3.2	3.4	3.5
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	43.1	39.5	41.3	40.3	38.6
Хүүхэд (өрхөд эзлэх хувь)	25.1	29.0	24.7	24.3	25.1	24.5
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	45.5	45.3	45.8	45.8	44.9
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	77.0	84.7	80.0	76.8	78.9	73.1
Хотжилт (%)	63.6	30.1	38.4	38.5	40.1	100.0

Санамж: Нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2014 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо юм. Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

2. Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгууд, Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон аймгууд, Төвийн бүсэд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгууд, Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд багтдаг.

суудаг хэдий ч ядуучуудын 18.2 хувь нь, Хангайн бүсэд хүн амын 19.4 хувь оршин суудаг боловч ядуучуудын 22.2 хувь нь, Төвийн бүсэд хүн амын 16.2 хувь амьдарч байгаа мөн ядуучуудын 16.2 хувь нь, Зүүн бүсэд хүн амын 6.9 хувь нь оршин суугаа боловч ядуучуудын 10.8 хувь нь тус тус амьдардаг байна. Харин Улаанбаатар хотод нийт хүн амын 44.7 хувь нь, ядуучуудын 32.6 хувь нь амьдарч байна. Хэдийгээр Улаанбаатар хотод ядуурлын хамралтын хүрээ хамгийн бага буюу 16.4 хувь байгаа боловч бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн их ядуучууд буюу 206.4 мянган ядуу хүмүүс амьдарч байна.

Хүснэгт 1.4-т ядуурлын байдлыг

дөрвөн үндсэн суурьшлаар харууллаа. Хотод ядуурал хөдөөгөөс нэлээн бага буюу хамралтын хүрээ нь 18.8 хувь, хөдөөд 26.4 хувь байна. Хотыг суурьшлаар нь авч үзвэл ядуурлын хамралтын хүрээ Улаанбаатар хотод аймгийн төвүүдийнхээс бага байна. Хөдөөг суурьшлаар нь авч үзвэл сумын төвд хөдөө нутгийг бодвол ядуурал бага байна. Хотод нийт хүн амын 66.4 хувь нь, ядуучуудын 55.6 хувь нь амьдарч байна. Харин сумын төвд нийт хүн амын 12.7 хувь нь, ядуучуудын 19.7 хувь нь, хөдөөд нийт хүн амын 20.9 хувь нь, ядуучуудын 24.7 хувь нь амьдарч байна.

Дээрх үр дүн ядуурлын шугамын

Хүснэгт 1.4. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар


	Улсын дундаж	Хот			Хөдөө		
		Нийт	Улаанбаатар	Аймгийн төв	Нийт	Сумын төв	Хөдөө нутаг
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	18.8 (0.9)	16.4 (1.2)	23.8 (1.0)	26.4 (1.0)	24.7 (1.1)	27.9 (1.5)
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	4.9 (0.3)	4.5 (0.4)	5.8 (0.3)	5.8 (0.3)	5.7 (0.4)	6.0 (0.4)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	1.9 (0.1)	1.7 (0.2)	2.1 (0.1)	2.0 (0.1)	2.0 (0.2)	1.9 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувь (%)	100.0	66.4	44.7	21.7	33.6	12.7	20.9
Хүн ам (мян.хүн)	2937.9	1951.8	1314.5	637.3	986.2	372.9	613.2
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин(%)	100.0	55.6	32.6	23.0	44.4	19.7	24.7
Ядуурлын шугамаас доогуур хүн амын тоо (мян.хүн)	634.0	352.3	206.4	145.9	281.7	125.2	156.6
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.5	3.5	3.5	3.5	3.4	3.7
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	39.2	38.6	40.4	41.3	42.2	40.3
Хүүхэд (өрхөд эзлэх хувь)	25.1	24.6	24.5	24.8	26.1	25.1	27.1
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	45.3	44.9	46.1	45.3	46.4	44.2
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	77.0	73.9	73.1	75.4	82.6	77.5	87.7

Санамж: Нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2014 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо юм. Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

3. Нэг графикт 2 ба түүнээс дээш суурьшлаар нэг хүнд ногдох хэрэглээг дүрсэлснээр хамгийн давуу талтай байгаа суурьшлыг тодорхойлж болох юм.

түвшнээс хэр зэрэг хамаарч байна вэ? Таамаглал дэвшүүлэх шинжилгээний аргыг ашиглан харьцуулах боломжтой ядуурлын шугамуудыг гаргаж авлаа. График³ ашиглан уг хэрэглээний тархалтыг бүхэлд нь авч үзье (Зураг 1.3).

Зураг 1.3. Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд сард ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт



Бүс нутгаар нь авч үзвэл Зүүн бүс, Баруун бүс, Хангайн бүсэд ядуурал хамгийн их байна. Баруун, Хангайн бүсийн муруй нь тархалтын ихэнх хэсэгт хоорондоо давхцаж байгаа учраас тэдгээрийг харьцуулж үзэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, ядуурлын шугамыг өөр өөрөөр сонгосон ч эдгээрийн ядуурлын хамралтын хүрээнүүд хоорондоо тун ойролцоо гарч байна. Зүүн бүсийн хувьд ядуурлын шугамыг 200.0 мянган төгрөг хүртэлх түвшинд өөр өөрөөр сонгоход бусад бүсүүдтэй адилгүйгээр өөрчлөгдөхөөр байна. Ядуурлын хамралтын хүрээ Улаанбаатар хотод хамгийн бага, хоёрдугаарт Төвийн бүс орж байна. Хот, хөдөө гэсэн байршлаар нь харьцуулахад өмнөх жилүүдэд харагдаж байсан хандлага тэр хэвээр хадгалагдсаар байна. Харин Улаанбаатар хотод амьжиргаа хамгийн сайтай ба бусад байршилд ойролцоо байгаа нь харагдаж байна.

1.4 Ядуурлын чиг хандлага

Сүүлийн жилд ядуурлын төлөв байдал хэрхэн өөрчлөгдсөнийг Хүснэгт 1.5-д харуулав. Сүүлийн жилд ядуурал буурсаныг ядуурлын хамралтын хүрээ, гүнзгийрэлт, мэдрэмжийн тооцооны дүн харуулж байна. Ядуурлын хамралтын хүрээ 2012 онд 27.4 байснаа 2014 онд 21.6 болж 5.8 пунктээр буурчээ. Хотод ядуурал 23.3 хувиас 18.8 хувь, хөдөөд 35.4 хувиас 26.4 хувь болж буурсан байна. Бүх суурьшилд ядуурал буурсан дүнтэй байна. Тухайлбал, хөдөө нутагт хамгийн их буюу 11.7 пунктээр, аймгийн төвд 6.6 пунктээр, Улаанбаатар хотод 3.5 пунктээр, сумын төвд 2.8 пунктээр тус тус буурсан байна. Бүс нутгуудад ядуурлын хамралтын хүрээ мөн буурсан дүнтэй байна. Хангайн

Хүснэгт 1.5. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2012, 2014 он

	2012 он				2014 он			
	Ядуурлын Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт Мэдрэмж	Хүн амын хувийн жин (%)	Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	Ядуурлын Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт Мэдрэмж	Хүн амын хувийн жин (%)	Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)
Улсын дундаж	27.4	7.1	100.0	100.0	21.6	5.2	1.9	100.0
Хот	23.3	6.2	65.9	56.3	18.8	4.9	1.9	66.4
Хөдөө	35.4	8.8	34.1	43.7	26.4	5.8	2.0	33.6
Улаанбаатар	19.9	5.1	44.6	32.4	16.4	4.5	1.7	44.7
Аймгийн төв	30.4	8.4	21.3	23.9	23.8	5.8	2.1	21.7
Сумын төв	27.5	7.3	12.7	11.8	24.7	5.7	2.0	12.7
Хөдөө нутаг	39.6	9.6	21.4	31.9	27.9	6.0	1.9	20.9
Баруун	32.3	7.7	12.9	16.0	26.0	5.3	1.7	12.8
Хангай	38.5	10.1	19.0	27.0	25.3	5.4	1.7	19.4
Төв а)	28.2	7.2	16.6	15.6	22.2	5.5	2.1	16.2
Зүүн	33.4	9.8	6.9	9.0	31.4	8.6	3.3	6.9

а/ Улаанбаатар хотыг оруулаагүй.
Эх сурвалж: ӨНЭЭС 2012, ӨНЭЭС 2014.


бүсэд ядуурлын хамралтын хүрээ 38.5 хувиас 25.3 хувь, Баруун бүсэд 32.3 хувиас 26.0 хувь, Төвийн бүсэд 28.2 хувиас 22.2 хувь болж буурсан харин Зүүн бүсэд бага зэрэг буюу 2.0 пунктээр буурчээ. Ядуурлын бусад үзүүлэлтүүд энэ хугацаанд хэрхэн өөрчлөгдсөнийг сонирхоё. Хот, хөдөөгийн харьцаа хэвээрээ буюу ядуурал хотод хөдөөгөөс бага байна. Ядуурал Улаанбаатар хотод хамгийн бага байна. Аймгийн төв болон сумын төвийн ядуурлын хамралт ойролцоо түвшинд байна. Харин сумын төвүүд хөдөө нутгаас ядуурал багатай байна. Өмнөх жилүүдийн адил хотод ядуу хүн амын тал гаруй хувь нь амьдарсан хэвээр байна. Гэхдээ хотын ядуу хүн амын эзлэх хувийн жин бага зэрэг буурсан, хөдөөгийн ядуу хүн амын эзлэх хувийн жин бага зэрэг өссөн байна. Бүсүүдэд ядуурлын байдал нэлээн өөрчлөгдсөн байна. Хангайн бүсэд ядуурал харьцангуй багасчээ. Ядуучуудын эзлэх хувийн жин бүсүүдэд бага зэрэг өөрчлөгджээ. Хангайн бүсийн ядуучуудын эзлэх хувийн жин 2012 оныхоос 4.8 пунктээр буурсан хэдий ч бусад бүсүүдтэйгээ харьцуулахад өндөр хэвээр байна. Баруун бүсийн ядуучуудын эзлэх хувийн жин хоёр жилийн өмнөхөөсөө 2.2 пункт, Зүүн бүсийнх 1.8 пункт, Төвийн бүсийнх бага зэрэг буюу 0.6 пунктээр өссөн байна. Ядуурал буурахад нийгэм, эдийн засгийн эерэг хүчин зүйлүүд болон төр засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрийн үр дүн нөлөөлөх нь дамжиггүй юм. Тодруулбал, 2014 онд 2012 онтой харьцуулахад дотоодын нийт бүтээгдэхүүн 20.3 хувиар өсч, ажилгүйдлийн түвшин 4.0 хувиар буурч, малын тоо 52.0 сая толгой болж, 27.0 хувиар өссөн зэрэг эерэг үр дүн харагдахын зэрэгцээ 2011-2014

онуудад төрөөс үндэсний үйлдвэрт хонь, тэмээний ноос, арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгосон бөгөөд нийт дүнгээрээ 2013-2014 онд ноосны урамшуулалд 53.3 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 2.9 тэрбум төгрөгийг малчдад олгожээ.

1.5 Цаг хугацааны харьцуулалт ядуурлын шугамын түвшнээс хамаарах нь

Цаг хугацааны өөрчлөлтөнд хүн амын хэрэглээний тархалт ядуурлын шугамын түвшнээс хэрхэн хамаарч байгааг таамаглал дэвшүүлэх шинжилгээний аргаар тодруулж болно.

Зураг 1.4. Нэг хүнд сард ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт 2012, 2014 он



Зураг 1.4-өөс харахад 2014 оны хэрэглээний тархалт 2012 оныхоос доогуур байна. Өөрөөр хэлбэл 2014 оны ядуурал 2012 оныхоос харьцангуй бага байна. Тархалтын нэлээн дээд хэсэг буюу нэг хүнд сард ногдох хэрэглээ дөрвөн зуун мянган төгрөгнөөс дээш үед хоёр муруй давхцсан байна.

1.6 Тэгш бус байдал

Хүснэгт 1.6-д Жини коэффициент болон Ерөнхий Энтропийн индексүүдийн⁴ өнгөрсөн хугацаанд гарсан өөрчлөлтийг харуулав. Өнгөрсөн хоёр жилд улсын хэмжээнд нэг хүнд ногдох хэрэглээний тэгш бус байдал буурсныг гурван үзүүлэлт харуулж байна. Жишээ нь, улсын хэмжээнд Жини коэффициент 0.34-өөс 0.32 болж буурсан бөгөөд үүний дотор хөдөөд хотоос илүү их буурсан байна.

Шинжилгээнд хамаарах хугацаанд дундаж хэрэглээнд гарсан өөрчлөлтүүдийг судалснаар зарим

дүгнэлт хийж болно. Нэг хүнд ногдох бодит хэрэглээ 2014 онд 2012 оноос 4.7 хувиар өссөн байна. Хот, хөдөөд хүн амын хэрэглээ 4.7-6.8 хувиар өссөн ба хөдөөгийн хэрэглээ хоттой харьцуулахад илүү өсөлттэй байна. Сумын төвийнхний хэрэглээ бараг хэвээрээ байгаа бол хөдөө нутгийнхны хэрэглээ 9.2 хувийн өсөлттэй байна. Аймгийн төвийн өрхүүдийн хэрэглээний өсөлт харьцангуй өндөр буюу 9.5 хувь байна. Бүсүүдээр харвал, дундаж хэрэглээ бүх бүсүүдэд нэмэгдсэний дотор Хангайн бүсэд харьцангуй их, Зүүн бүсэд харьцангуй бага нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.6. Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ 2012, 2014 он

	Тейлийн индекс		Жини коэффициент		GE(2)		Нэг хүнд сард ногдох хэрэглээ		
	2012	2014	2012	2014	2012	2014	2012	2014	Өсөлт
Улсын дундаж	0.20	0.19	0.34	0.32	0.28	0.27	256 054	268 069	4.7
Хот	0.21	0.20	0.34	0.33	0.29	0.28	277 086	290 123	4.7
Хөдөө	0.16	0.15	0.31	0.28	0.21	0.21	214 841	229 471	6.8
Улаанбаатар	0.20	0.20	0.34	0.33	0.28	0.29	296 670	305 380	2.9
Аймгийн төв	0.19	0.18	0.33	0.32	0.28	0.26	236 413	258 855	9.5
Сумын төв	0.16	0.16	0.31	0.29	0.19	0.24	240 457	240 228	-0.1
Хөдөө нутаг	0.16	0.13	0.30	0.27	0.21	0.17	201 233	219 737	9.2
Баруун	0.15	0.16	0.30	0.28	0.18	0.26	222 203	232 646	4.7
Хангай	0.17	0.15	0.31	0.29	0.22	0.20	204 229	233 923	14.5
Төв а)	0.20	0.17	0.33	0.31	0.30	0.24	250 366	262 308	4.8
Зүүн	0.17	0.16	0.31	0.31	0.21	0.20	218 716	224 516	2.7

а/ Улаанбаатар хотыг оруулаагүй.

Санамж: Хоёр үеийн ядуурлын шугамын харьцаан дээр үндэслэн 2012 оныг 2014 оны үнээр илэрхийлэв.


GE(a) индексээр тэгш бус байдлын хэмжүүрүүдийн Ерөнхий Энтропи ангийг тэмдэглэсэн бөгөөд а-ийн утга их (бага) байх тусам тархалтын дунд хэсэгт хэрэглээний ялгавраас бүр их хамааралтай болдог.

Эх сурвалж: ӨНЭЗС 2012, ӨНЭЗС 2014.

4. Тэгш бус байдлын Ерөнхий Энтропи ангийн хэмжүүрүүдийг GE(α) гэж тэмдэглэдэг. α утга ихсэх (багасах) тусам тархалтын дээд (доод) хэсэг дэх хэрэглээний өөрчлөлтөөс энэ үзүүлэлт илүү хүчтэй хамаардаг. Жини коэффициент нь тархалтын дунд хэсэг дэх хэрэглээний өөрчлөлтөөс илүү хамаардаг. Энэ гурван индекс гурвуулаа тэгээс нэг хүртэл утга авах бөгөөд утга нь өсөх тусам тэгш бус байдал их байна.

Түүнчлэн тэгш бус байдлын шинжилгээнд Лоренцын муруйн аргыг бас хэрэглэдэг. Лоренцын муруй нь хүн амыг хамгийн ядуугаас нь чинээлэг баян руу нь эрэмбэлэн хүн амын хувийн жинг түүнд харгалзах хэрэглээний жинд харгалзуулан үзүүлдэг. Зураг 1.5-д Лоренцын муруйг хот, хөдөөгөөр харуулав. Лоренцын муруй тэгш хуваарилалтын шугамнаас алслагдах тусам тэгш бус байдлын түвшин нэмэгддэг. Лоренцын муруйнаас харахад хотод хөдөөгөөс илүү тэгш бус байдал өндөр байгааг харж болно.

Зураг 1.5. Нэг хүнд сард ногдох хэрэглээ: Лоренцын муруй



Тэгш бус байдлыг хэмжих өөр нэг арга буюу магадгүй илүү ойлгомжтой арга бол Зураг 1.6, 1.7-д дүрслэн үзүүлсэн хүн амыг хэрэглээний түвшингээр нь тэнцүү 5, 10 бүлэгт хуваах (нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр нь хүн амыг ядуугаас нь баян руу нь эрэмбэлэн, улмаар 10, 20-н хувиар буюу тэнцүү 5, 10-н бүлэгт хуваана) арга юм.


Зураг 1.6-гаас харахад хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхний хэрэглээний дундаж хэмжээ ядуу 20 хувийнхнаас 5.0 дахин өндөр байна.

Зураг 1.6. Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 5 бүлгээр



Харин хэрэглээний 10 тэнцүү бүлгийн хувьд хүн амын чинээлэг 10 хувийн хэрэглээний дундаж хэмжээ хамгийн ядуу 10 хувийнхнаас 7.7 дахин өндөр байна. Энэ харьцаа хотод 8.4, хөдөөд 6.0 байгаа нь хотод хэрэглээний тэгш бус байдал өндөр байгааг мөн харуулж байна.

Зураг 1.7. Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 10 бүлгээр, хот хөдөөгөөр



1.7 Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь

Дундаж хэрэглээ өсөх, хэрэглээний тэгш бус байдал нэмэгдэх нь ядууралд хэрхэн нөлөөлдөг вэ? Бусад хүчин зүйлүүд өөрчлөгдөөгүй байхад хэрэглээ өссөнөөр ядуурал буурч, харин тэгш бус байдал өссөнөөр ядуурал нэмэгдэх хандлагатай байдаг. Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваан үзсэнээр дээрхи хандлагыг бүр тодорхой харж болно.⁵ Бодит дундаж хэрэглээ өөрчлөгдөж, харин тэгш бус байдал өөрчлөгдөөгүй нөхцөлд үүсэх өөрчлөлт нь ядуурлын өөрчлөлтийн өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг юм. Харин тэгш бус байдал өөрчлөгдөж, бодит дундаж хэрэглээ өөрчлөгдөөгүй үед үүсэх өөрчлөлтийг ядуурлын өөрчлөлтийн тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг гэж үзнэ. Хүснэгт 1.7-д ядуурлын өөрчлөлтийг дээрх бүрэлдэхүүний бүтцээр харууллаа.

Улсын хэмжээнд өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг аль аль нь ядуурал буурахад нөлөө үзүүлжээ. Жишээ нь, 2012 болон 2014 оны хооронд ядуурлын хамралтын хүрээ улсын хэмжээнд 5.8 пунктээр буурчээ. Хэрэв энэ хугацаанд тэгш бус байдал өөрчлөгдөөгүй бол хэрэглээний өсөлтийн улмаас ядуурал 2.7 пунктээр, бодит дундаж хэрэглээ өсөөгүй бол тэгш бус байдал буурснаас болж ядуурал 3.1 пунктээр буурах байлаа. Эдгээр хоёр хүчин зүйлийн нөлөөгөөр ядуурлын цэвэр бууралт 5.8 пункт болжээ.

Харин гүнзгийрэлтийн хувьд хамралтын хүрээтэй адилаар тэгш бус байдал өөрчлөгдсөн нь ядуурлын гүнзгийрэлт буурахад хэрэглээний өсөлтөөс илүү нөлөө үзүүлсэн байна. Ядуурлыг хэмжих өөр нэг үзүүлэлт болох мэдрэмжийн индекс буурахад дээрх хоёр хүчин зүйлс адил нөлөө үзүүлсэн ба тэдгээрийн нөлөөллөөр ядуурлын мэдрэмжийн цэвэр бууралт 0.7 пункт байна. Хот, хөдөөгөөр авч үзвэл эдгээр хүчин зүйл хоёул нөлөөлсөн бөгөөд үүнээс өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг хөдөөгийн ядуурал буурахад голлон нөлөөлжээ. Хотод ядуурал 4.5 пунктээр буурсан бөгөөд энэ хугацаанд хотод тэгш бус байдал өөрчлөгдөөгүй бол ядуурал 2.3 пунктээр буурах байжээ. Хөдөөд ядуурал 9.1 пунктээр буурсан бөгөөд энэ хугацаанд тэгш бус байдал өөрчлөгдөөгүй бол ядуурал 4.9 пунктээр, бодит дундаж хэрэглээ өсөөгүй бол ядуурал 4.1 пунктээр буурах байжээ. Суурьшлуудаар тооцож үзэхэд өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүд аль аль нь ядуурал буурахад нөлөөлсөн байна. Аймгийн төв болон хөдөө нутагт өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг, Улаанбаатар хот болон сумын төвд тэгш бус байдлын өөрчлөлт ядуурал буурахад илүү нөлөөлжээ. Баруун болон Төвийн бүсийн ядуурлын бууралтад өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүд аль аль нь ижил хэмжээгээр нөлөөлсөн. Харин Хангайн бүсийн хувьд хэрэглээний өсөлт өндөр байгаа бөгөөд үүний үр дүнд Хангайн бүсийн ядуурлын хамралтын хүрээ нэлээд буурсан байна. Зүүн бүсэд хэрэглээ өссөн нь ядуурал буурахад, тэгш бус байдлын өөрчлөлт нь ядуурал өсөхөд нөлөөлжээ.

5. "Ядуурлын харьцуулалт" гарын авлага, Мартин Раваллион (1992)

Хүснэгт 1.7. Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь 2012, 2014 он

	Ядуурлын		
	Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж
Улсын дундаж			
Ядуурлын өөрчлөлт	-5.8	-1.8	-0.7
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-2.7	-0.8	-0.4
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-3.1	-1.0	-0.4
Хот			
Ядуурлын өөрчлөлт	-4.5	-1.3	-0.5
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-2.3	-0.7	-0.3
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-2.1	-0.6	-0.2
Хөдөө			
Ядуурлын өөрчлөлт	-9.1	-3.0	-1.2
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-4.9	-1.6	-0.6
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-4.1	-1.4	-0.6
Улаанбаатар			
Ядуурлын өөрчлөлт	-3.5	-0.7	-0.2
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-1.3	-0.4	-0.2
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-2.2	-0.3	-0.1
Аймгийн төв			
Ядуурлын өөрчлөлт	-6.6	-2.6	-1.2
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-5.3	-1.8	-0.8
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-1.3	-0.8	-0.4
Сумын төв			
Ядуурлын өөрчлөлт	-2.8	-1.6	-0.8
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	0.0	0.0	0.0
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-2.8	-1.6	-0.8
Хөдөө нутаг			
Ядуурлын өөрчлөлт	-11.7	-3.7	-1.4
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-7.0	-2.3	-0.9
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-4.7	-1.4	-0.5
Баруун			
Ядуурлын өөрчлөлт	-6.3	-2.4	-0.9
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-3.2	-1.0	-0.4
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-3.1	-1.3	-0.5
Хангай			
Ядуурлын өөрчлөлт	-13.2	-4.6	-2.0
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-10.0	-3.3	-1.3
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-3.2	-1.4	-0.7
Төв а/			
Ядуурлын өөрчлөлт	-5.9	-1.7	-0.6
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-3.0	-0.9	-0.4
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-2.9	-0.8	-0.2
Зүүн			
Ядуурлын өөрчлөлт	-2.0	-1.3	-0.8
Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-2.1	-0.6	-0.3
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	0.1	-0.6	-0.5

а/ Улаанбаатар хотыг оруулаагүй.
Эх сурвалж: ӨНЭЗС 2012, ӨНЭЗС 2014.

2.

АЖ БАЙДЛЫН ДҮР ТӨРХ

Аж байдлын дүр төрх нь хүн амын янз бүрийн бүлгүүдэд амьжиргааны түвшин ямар байгааг харуулдаг. Энэ бүлэгт ядуурлын шинж чанар, тэдгээр нь өрхийн ялгаатай байдал болон аж байдлын бусад үзүүлэлтүүдтэй хэрхэн холбогдож байгааг харуулж, ядуурлын ерөнхий төрхийг авч үзнэ. Ингэснээр ядуучуудыг ядуу бус хүмүүсээс ялгах, ядуу хүн гэж хэн бэ, тэдний хүмүүний капитал, эзэмшиж буй эдийн засгийн нөөц баялгийн түвшин, амьдарч байгаа сууцны чанар, хүртэж буй нийгмийн хамгаалал, эрхэлж байгаа ажлын төрөл зэргийг тодорхойлох бололцоотой болох юм.

2.1 Хэрэглээний хэв шинж

Бид өрхийн нэг хүнд ногдох хэрэглээг хүн амын аж байдлыг тодорхойлох, харьцуулж болохуйц үзүүлэлт болгон сонгосон. Судалгааны дүнгээр Монгол улсын нэг хүнд ногдох сарын хэрэглээ 2014 онд дунджаар 268 069 төгрөг⁶ байна. Хүн амын дундаж хэрэглээг зардлын үндсэн бүлгүүдээр болон хот, хөдөө, бүс нутгаар Хүснэгт 2.1-д харуулав. Хот, суурин газрын хүн амын хэрэглээний түвшин хөдөөнийхөөс 26 хувиар их байна. Бүсүүдийг хэрэглээний түвшингээр нь эрэмбэлэн үзвэл Төвийн бүс хамгийн өндөр дараа нь Хангай, Баруун, хамгийн сүүлд Зүүн бүс орж байна. Өмнөх жилүүдэд Хангайн бүсийн хэрэглээ хамгийн бага байсан бол энэ жил харьцангуй өссөн байна.

Хүн амын хэрэглээний бүтцийг хүснэгтийн доод хэсэгт үзүүллээ. Хүнс нь нийт хэрэглээний 33.6 хувийг эзлэх гол бүрдэл хэсэг болж байгаа нь хэвээр боловч нийт хэрэглээний дүнд эзлэх хувь хэмжээ нь хот, хөдөөд нэлээд ялгаатай байна. Хот суурин газрын аж байдлын түвшин хөдөөнийхөөс өөр бөгөөд хүнсний бүтээгдэхүүний хувийн жин нь ерөнхийдөө бага байдаг. Нийслэл хот, аймгийн төвд хүнсний хувь хэмжээ нь 31 хувь байна. Харин сумын төв болон хөдөөд хүнсний хэрэглээний нийт хэрэглээнд эзлэх хувийн жин хоорондоо нилээн ялгаатай байна. Бүс нутгуудын хувьд хүнсний хувийн жин ерөнхийдөө ойролцоо буюу 36-гаас 37 хувь буюу 2012 онтой харьцуулахад багассан эерэг үзүүлэлт байна.

Хүнсний бус нэр төрлүүдийн дотроос хамгийн том бүрэлдэхүүн

хэсэг нь гутал, хувцасны зардал бөгөөд улсын дунджаар нийт хэрэглээний 17 хувийг эзэлж байна. Энэ хэмжээ хот, хөдөөд 2012 оныхтой ижил байна. Тээвэр, холбооны зардал нь нийт хэрэглээний 12 хувийг эзэлж байгаа бөгөөд нийслэл хотод хамгийн өндөр, харин бусад гурван суурьшилд ойролцоо, бүсүүдийн хувьд мөн ойролцоо байна. Боловсролын зардал нь нийт хэрэглээний 5 хувь болж байгаа бөгөөд Баруун бүсэд хамгийн өндөр буюу 7 хувь, бусад бүх байршилд харьцангуй ойролцоо байгаа юм. Сууцны хэрэглээ нь нийт хэрэглээний 8 хувь болж байгаа бөгөөд хотод 10 хувь, хөдөөд 2 хувь байна. Эрүүл мэндийн зардал 5 хувь ба хот, хөдөөд ойролцоо байгаа бөгөөд суурьшлаар харвал аймгийн төвд харьцангуй өндөр буюу 7 хувьтай байна. Бүсийн хувьд Баруун бүсэд хамгийн их буюу 8 хувь, Хангай ба Төвийн бүсэд хамгийн бага буюу 5 хувь байна. Халаалтын зардал нийт хэрэглээний 4 хувь болж байгаа бөгөөд хот, хөдөөгийн хувьд улсын дундажтай ойролцоо байна. Ус, цахилгаан, гэрэлтүүлэг зэрэг ахуйн хэрэглээ 2 хувь болж байна. Нийт хэрэглээний үлдсэн 14 хувь нь амралт чөлөөт цаг, гоо сайхан, удаан эдэлгээт бараа болон архи, тамхинд ноогдож байна.

6. Мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн мэдээлэл нь оны үнээр тооцогдсон болно

Хүснэгт 2.1. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, төгрөгөөр

	Улсын дундаж				Суурьшлагаар				Бус нутаг			
	Улсын дундаж	Хот	Хөдөө	Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө нутаг	Баруун	Хангай	Төв а/	Зүүн	
												Хөдөө
Хэрэглээ, төгрөг												
Хүнс	90 028	89 075	91 697	93 429	80 152	87 546	95 453	83 613	84 529	97 395	81 884	
Согтууруулах ундаа, тамхи	3 407	2 039	5 801	1 984	2 152	5 682	5 908	3 278	4 970	5 190	4 088	
Боловсрол	13 532	15 212	10 591	15 708	14 196	11 714	9 575	15 935	11 045	10 795	8 254	
Эрүүл мэнд	13 505	14 226	12 243	12 331	18 109	15 330	9 449	18 881	12 051	13 555	12 942	
Удаан эдэлгээтэй бараа 1/	9 451	11 252	6 298	12 556	8 578	7 193	5 488	5 664	7 018	8 246	8 029	
Түрээс 2/	20 602	29 357	5 281	35 109	17 567	8 162	2 674	5 604	9 475	13 916	10 127	
Халаалт 3/	10 027	10 608	9 011	10 312	11 216	10 357	7 792	11 114	9 744	9 447	8 126	
Үйлчилгээ 4/	6 213	8 296	2 566	9 010	6 832	4 705	631	2 711	3 544	6 070	4 333	
Хувцас	44 739	45 373	43 629	44 813	46 521	45 446	41 985	44 247	47 163	44 497	39 607	
Тээвэр холбоо	33 374	39 025	23 483	44 032	28 765	24 007	23 010	22 880	22 953	30 230	26 607	
Бусад 5/	23 191	25 660	18 871	26 096	24 767	20 086	17 772	18 719	21 431	22 967	20 519	
Нийт	268 069	290 123	229 471	305 380	258 855	240 228	219 737	232 646	233 923	262 308	224 516	
Хувийн жин, хувь												
Хүнс	33.6	30.7	40.0	30.6	31.0	36.4	43.4	35.9	36.1	37.1	36.5	
Согтууруулах ундаа, тамхи	1.3	0.7	2.5	0.6	0.8	2.4	2.7	1.4	2.1	2.0	1.8	
Боловсрол	5.1	5.2	4.6	5.1	5.5	4.9	4.4	6.9	4.7	4.1	3.7	
Эрүүл мэнд	5.0	4.9	5.4	4.0	7.0	6.4	4.3	8.1	5.1	5.2	5.8	
Удаан эдэлгээтэй бараа 1/	3.5	3.9	2.8	4.1	3.3	3.0	2.5	2.4	3.0	3.1	3.6	
Түрээс 2/	7.7	10.1	2.3	11.5	6.8	3.4	1.2	2.4	4.1	5.3	4.5	
Халаалт 3/	3.7	3.7	3.9	3.4	4.3	4.3	3.5	4.8	4.2	3.6	3.6	
Үйлчилгээ 4/	2.3	2.9	1.1	3.0	2.6	1.9	0.3	1.2	1.5	2.3	1.9	
Хувцас	16.7	15.6	19.0	14.7	18.0	18.9	19.1	19.0	20.2	17.0	17.6	
Тээвэр холбоо	12.4	13.5	10.2	14.4	11.1	10.0	10.5	9.8	9.8	11.5	11.9	
Бусад 5/	8.7	8.8	8.2	8.6	9.6	8.4	8.1	8.1	9.2	8.8	9.1	
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	

а/ Улаанбаатар хотыг оруулаагүй.

1/ Удаан эдэлгээт барааг ашигласнаас үүссэн хэрэглээг мөнгөн дүнгээр илэрхийлэв.

2/ Сууц эзэмшсэнээс гарч буй хэрэглээг мөнгөн дүнгээр тооцсон. Хэрэв тухайн өрх сууцаа түрээслэн ашиглаж байгаа бол тооцолсон утгыг биш харин түрээсийн жинхэнэ утгыг авна.

3/ Төвлөрсөн болон орон нутгийн халаалт, мод, нүүрс, аргал, хөрсөн орно.

4/ Гэрэл, цахилгаан, усны хэрэглээг тооцсон бөгөөд телефон утсыг оруулаагүй.

5/ Амралт, чөлөөт цаг, үзвэр, гоо сайхан, ариун цэврийн бараа болон гэр ахуйн хэрэгсэл орно.

Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

Хүснэгт 2.2. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, ядуурлын байдлаар, хот, хөдөөгөөр

	Нийт		Хот		Хөдөө	
	Ядуу бус	Ядуу	Ядуу бус	Ядуу	Ядуу бус	Ядуу
Хэрэглээ, төгрөг						
Хүнс	100 787	50 937	98 850	46 974	104 523	55 892
Согтууруулах ундаа, тамхи	3 837	1 842	2 287	972	6 829	2 929
Боловсрол	16 124	4 110	17 768	4 202	12 954	3 994
Эрүүл мэнд	16 607	2 231	16 993	2 310	15 864	2 133
Удаан эдэлгээтэй бараа 1/	11 441	2 219	13 348	2 226	7 762	2 212
Түрээс 2/	25 231	3 783	34 998	5 061	6 390	2 186
Халаалт 3/	10 868	6 973	11 206	8 031	10 214	5 650
Үйлчилгээ 4/	7 169	2 739	9 326	3 860	3 007	1 336
Хувцас	52 092	18 019	52 172	16 089	51 938	20 433
Тээвэр холбоо	40 058	9 089	45 834	9 703	28 914	8 321
Бусад 5/	27 077	9 073	29 515	9 058	22 374	9 092
Нийт	311 291	111 015	332 297	108 486	270 769	114 178
Хувийн жин, хувь						
Хүнс	32.4	45.9	29.7	43.3	38.6	48.9
Согтууруулах ундаа, тамхи	1.2	1.6	0.7	0.9	2.5	2.6
Боловсрол	5.2	3.7	5.4	3.9	4.8	3.5
Эрүүл мэнд	5.3	2.0	5.1	2.1	5.8	1.9
Удаан эдэлгээтэй бараа 1/	3.7	2.0	4.0	2.1	2.9	1.9
Түрээс 2/	8.1	3.4	10.5	4.7	2.3	1.9
Халаалт 3/	3.5	6.3	3.4	7.4	3.8	4.9
Үйлчилгээ 4/	2.3	2.5	2.8	3.6	1.1	1.2
Хувцас	16.7	16.2	15.7	14.8	19.2	17.9
Тээвэр холбоо	12.9	8.2	13.8	8.9	10.7	7.3
Бусад 5/	8.7	8.2	8.9	8.3	8.3	8.0
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

1/ Удаан эдэлгээт барааг ашигласнаас үүссэн хэрэглээг мөнгөн дүнгээр илэрхийлэв.

2/ Сууц эзэмшсэнээс гарч буй хэрэглээг мөнгөн дүнгээр тооцсон. Хэрэв тухайн өрх сууцаа түрээслэн ашиглаж байга бол тооцоолсон утгыг биш харин түрээсийн жинхэнэ утгыг авна.

3/ Төвлөрсөн болон орон нутгийн халаалт, мод, нүүрс, аргал, хөрзөн орно.

4/ Гэрэл, цахилгаан, усны хэрэглээг тооцсон бөгөөд телефон утсыг оруулаагүй.

5/ Амралт, чөлөөт цаг, үзвэр, гоо сайхан, ариун цэврийн бараа болон гэр ахуйн хэрэгсэл орно.

Эх сурвалж: ӨНЭЭС 2014.


Ядуу болон ядуу бус хүмүүсийн хэрэглээний байдал ихээхэн ялгаатай байна (Хүснэгт 2.2). Ядуу бус хүн ам ядуучуудаас 3 дахин их хэрэглээтэй, мөн ядуу бус хүн амын хүнсний дундаж хэрэглээ ядуучуудын хүнсний дундаж хэрэглээнээс хоёр дахин их байна. Ядуучуудын нийт хэрэглээнд хүнсний хувийн жин өндөр буюу 45.9 хувийг эзэлж байна. Ядуучуудын хүнсний хэрэглээ нь ядуу бус хүн амыг бодвол нийт хэрэглээнд нь илүү өндөр хувь эзэлдэг тул хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт тэдэнд илүү хүндээр тусах нь тодорхой юм. Ядуу бус хүн

амын боловсролын дундаж зардал ядуучуудынхаас 4 дахин их боловч дүнд эзлэх хувь хэмжээгээр авч үзвэл ядуу бус хүн амынх ядуу хүн амынхаас бага зэрэг л өндөр байна. Ядуу бус хүн амын эрүүл мэндийн дундаж зардал ядуучуудынхаас 7 дахин өндөр бөгөөд хувь хэмжээний хувьд ч илүү байна. Ядуу бус хүн ам халаалтандаа ядуучуудаас илүү зардал гаргадаг боловч нийт хэрэглээнд эзлэх хувь хэмжээгээрээ ядуу хүн амынх илүү байна. Ядуу бус хүн амын хувцасны зардал ядуучуудынхаас 3 дахин их боловч ядуу болон ядуу бус хүн амын

хувцасны зардлын нийт хэрэглээнд эзлэх хувь хэмжээ ойролцоо байна. Эцэст нь тэмдэглэхэд, ядуу бус хүн ам тээвэр, холбооны зардалд ядуу хүн амыг бодвол харьцангуй ихийг зарцуулдаг байна.

2.2 Ядуурал улирлын хэлбэлзлээс хамаарах нь

Хүн амын хэрэглээний түвшин улирлаар хэлбэлзэхэд мал аж ахуй, газар тариалан эрхлэлтийн хүчин зүйлүүд хамгийн их нөлөөлдөг. Хүнсний хэрэглээний бүтэц нь улирлаар эрс өөрчлөгдөх буюу зун сүү, цагаан идээ, намар хүнсний ногоо, өвөл махыг түлхүү хэрэглэх боловч хавар ерөнхийдөө тарчигдуу байдаг. Намартаа сүү, цагаан идээ сайтай, махны хангамж бас сайжирдаг тул дөрвөн улирал дотроо хүнсний хэрэглээ хамгийн өндөр, харьцангуй элбэг, дэлбэг улирал юм. Бид өмнөх тайлантай харьцуулах боломжийг хангахын тулд Монгол орны байгалийн дөрвөн улирлаар бус харин хуанлийн дөрвөн улирлаар⁷ дүн шинжилгээ хийлээ. Судалгаа явуулсан нэг жилийн хугацаанд хүн амын аж байдал бүх улирлын хувьд өөрчлөлт багатай, тогтвортой байсан гэж хэлж болох боловч гуравдугаар улирлын хувьд хүн амын амьжиргаа арай дээгүүр, сайн байсан гэдгийг Зураг 2.1-ээс харж болно.



7. Монгол улсад 6-8-р сарууд нь зун, 9-11-р сарууд нь намар, 12-2 сарууд нь өвөл, 3-5 сарууд нь хаврын улиралд тооцогддог.

Ядуурлын хамралтын хүрээ нь судалгааны эхний улиралд 23.9 хувь байсан бол сүүлийн улирал буюу оны сүүлийн гурван сард 21.2 хувь болж буурсан бөгөөд ерөнхийд нь харахад хүн амын амьжиргаа сүүлийн хагас жилд сайжирсан байна. Ядуурал гуравдугаар улиралд харьцангуй бага буюу 17.4 хувьтай болж буурсан хэдий ч дөрөвдүгээр улиралд 3.8 пунктээр нэмэгдсэн байна.

2.3 Өрхийн ам бүлийн бүтэц

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн ам бүлийн бүтэц хоорондоо ихээхэн ялгаатай байдаг. Зарим өрх нь үндсэн гэр бүлээс (эхнэр, нөхөр, хүүхдүүдээс бүрдсэн), нөгөө хэсэг нь өргөтгөсөн гэр бүлээс (эхнэр, нөхөр, хүүхдүүдээс гадна бусад хамаатнуудаас бүрдсэн) тус тус бүрдэж байхад зарим өрхүүд олон хүүхэдтэй, эсвэл зөвхөн өндөр настай хүмүүсээс бүрдсэн гэх мэтээр ялгаатай байна. Үүнээс ядуурал болон өрхийн ам бүлийн бүтцийн хооронд харилцан хамаарал байна уу? гэсэн асуулт гарч ирж байна. Хүснэгт 2.3-т өрхийн ам бүлийн тооноос шалтгаалж ядуурлын үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулав. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам ядуурлын хамралтын хүрээ жигд өсч байна. Энэ хандлага нь аж байдлын үзүүлэлтийг нэг хүнд ногдох хэрэглээгээр авч байгаа тохиолдолд тийм ч гайхмаар зүйл биш юм. Ганц бие хүний хувьд ядуу байх магадлал ойролцоогоор 2 хувь байна. Харин 2 ам бүлтэй өрхийн 5 хувь нь ядуу байна. Ийм өрхүүд нийт хүн амын 13 хувь, ядуучуудын 3 орчим хувийг эзэлж байна. Дундаж буюу 3-5 ам бүлтэй өрхүүдийн ядуурлын хамралтын хүрээ 11-27 орчим хувь болж байна.

Хүснэгт 2.3. Ядуурал ба өрхийн ам бүлийн тоо

	Улсын дундаж	Өрхийн ам бүлийн тоо							
		1	2	3	4	5	6	7	8-аас дээш
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	2.1 (0.4)	4.7 (0.5)	10.7 (0.7)	18.1 (0.9)	26.9 (1.2)	37.3 (1.8)	45.0 (3.2)	60.6 (3.9)
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	0.4 (0.1)	0.8 (0.1)	2.0 (0.2)	3.8 (0.2)	6.3 (0.4)	9.5 (0.6)	13.2 (1.3)	20.6 (1.9)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	0.1 (0.1)	0.2 (0.0)	0.6 (0.1)	1.2 (0.1)	2.2 (0.2)	3.5 (0.3)	5.4 (0.7)	9.3 (1.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:									
Хүн амын хувийн жин (%)	100.0	3.1	9.9	18.5	28.1	21.4	11.0	4.4	3.6
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	0.3	2.2	9.2	23.5	26.7	19.1	9.1	9.9
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	45.0	40.4	32.1	39.5	44.2	45.3	45.9	45.6
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.1	0.0	6.8	22.7	35.3	40.7	41.5	40.4	40.7
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	52.2	51.6	43.7	40.9	42.2	44.6	46.8	49.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	77.0	45.5	65.0	77.4	87.6	89.5	89.5	86.4	74.9

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЗС 2014.


Эдгээр өрх нийт хүн амын 68 хувийг, ядуучуудын 59 хувийг эзэлж байна. Харин зургаан ам бүлтэй өрхийн 37 орчим хувь нь, долоогоос дээш ам бүлтэй өрхийн бараг тал хувь нь ядуу байна. Эдгээр өрхөд амьдардаг хүмүүс нийт хүн амын 15 хувийг эзэлж байгаа боловч нийт ядуучуудын 28 хувийг бүрдүүлж байна. Наймаас дээш ам бүлтэй өрхүүдэд ядуурал их буюу 61 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна. Ийм тооны ам бүлтэй өрх нийт хүн амын 4 хувийг, ядуучуудын 10 хувийг бүрдүүлж байна.

Өрхийн ам бүлийн байдалд дүн шинжилгээ хийх хоёр дахь арга нь хүн ам зүйн ачааллын харьцаанд үндэслэдэг. Өрхийн ам бүлийн бүтцийг судлахад энэ үзүүлэлтийг өргөн ашигладаг бөгөөд өрхийн хөдөлмөрийн бус насны гишүүдийг өрхийн нийт гишүүдийн тоонд харьцуулсан харьцаа.⁸ Өөрөөр хэлбэл өрхөд байгаа “тэжээлгэгчдийн” хувийн жинг илэрхийлнэ. Зураг 2.2-т ядуурлын хамралтын хүрээ болон хүн ам зүйн ачааллын хоорондын хамаарлыг

харуулав. Хүн ам зүйн ачааллын харьцаа их байх тусам тухайн өрх ядууралд илүү өртөмтгий байна. Өрхийн ам бүлийн тоонд хүүхэд, өндөр настны эзлэх хувийн жин хөдөлмөр эрхэлж байгаа гишүүдийн хувийн жинтэй харьцуулахад өндөр байх нь “орлого олж буй” гишүүд өөрөөсөө гадна тодорхой тооны хүнийг тэжээж байгааг харуулах бөгөөд өрхийн гишүүн бүрт ногдох орлого ба хэрэглээний түвшин буурч ядуурал нэмэгдэнэ. Энэ харьцаа нь 70 хувь хүртэлх утгыг авдаг бөгөөд үүнээс дээш байгаа тохиолдолд ядуурал буурч байна. Энэ тохиолдолд эдгээр өрх нь ихэвчлэн ажил эрхэлж буй эсвэл тэтгэвэр авдаг, мөн хамаатнуудаасаа тусламж авдаг зэрэг тогтмол орлоготой өндөр настнуудаас бүрдсэн байдаг тул ядууралд өртөх нь багасч байгааг харуулна.

8. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн бус насны хүн ам ба хөдөлмөрийн насны хүн амын харьцаа буюу ерөнхийдөө 15, түүнээс доош насны ба 64-өөс дээш насны хүн амыг 15-64 насны хүн ам харьцуулсан харьцаагаар тодорхойлж болно. Тиймээс энэ нь өрхийн “орлого ологч” бүрт хэдэн “тэжээлгэгч” ногдож байгааг илэрхийлдэг. Гэхдээ Монгол Улсын нөхцөлд хөдөлмөрийн насыг тодорхойлохдоо өөр ангилал баримталдаг бөгөөд 16-59 насны эрэгтэйчүүд, 16-54 насны эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн насны хүн амд тооцдог.

Зураг 2.2. Ядуурал ба хүн ам зүйн ачааллын харьцаа



Хүн ам зүйн ачааллын харьцаа хөдөөд харьцангуй өндөр байна. Өөрөөр хэлбэл өрхөд байгаа “тэжээлгэгчдийн” хувийн жин хөдөөд илүү байна.

2.4 Өрхийн тэргүүлэгчийн шинж байдал

Ядуурлын талаарх зарим харьцуулалтыг хийхийн тулд өрхийн тэргүүлэгчийн тодорхой шинж байдлаар нь өрхүүдийг ангилах нь практикт элбэг байдаг⁹. Зарим сул тал байдаг ч энэ нь өрх хоорондын харьцуулалтыг хийх энгийн боловч чухал аргын нэг мөн¹⁰.

Өрхийн эдийн засгийн гол эх үүсвэр болон амьжиргааны байдлыг ихэнх тохиолдолд тодорхойлж байдаг өрхийн тэргүүлэгчийн шинж байдалтай тухайн өрхийн ам бүлийн байдал, амьжиргааны түвшний асуудал зайлшгүй хамааралтай. Энэ бүлэгт өрхийн тэргүүлэгчийн нас, хүйс,

Хүснэгт 2.4. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар

	Улсын дундаж	<30	30 - 39	40 - 49	50 - 59	>=60
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	18.5 (1.3)	26.1 (1.1)	22.8 (1.0)	19.6 (1.1)	14.1 (1.1)
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	4.2 (0.4)	6.4 (0.4)	5.6 (0.3)	5.3 (0.4)	2.7 (0.3)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	1.4 (0.2)	2.3 (0.2)	2.1 (0.2)	2.1 (0.2)	0.8 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	100.0	12.0	29.0	27.7	19.2	12.1
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	10.3	35.1	29.3	17.4	7.9
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.2	4.0	4.0	3.4	2.6
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	33.3	44.5	26.4	24.4	77.7
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.1	31.6	42.9	25.3	11.9	7.7
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	26.0	34.6	44.5	54.1	68.8
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	77.0	83.8	85.4	80.8	73.4	57.2

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

9. ӨНЭЭС-нд өрхийн тэргүүлэгчийн хувьд нарийн тодорхойлолтыг ашигласан. Өрхийн тэргүүлэгч гэдэг нь өрхийн бусад гишүүдийн хүлээн зөвшөөрсөн, бусдыг зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэдэг, өрхийн бэрхшээлтэй асуудлуудад ихэнх хариуцлагыг хүлээдэг, өрхийн санхүүгийн асуудлыг ихэвчлэн шийдвэрлэдэг гишүүн юм.

10. Сул талын тухай ярихад, жишээлбэл, хэдийгээр өрхийн хамгийн өндөр настай гишүүн дээрх тодорхойлолтонд тохирохгүй ч гэсэн түүнд хүндлэл үзүүлж өрхийн тэргүүн гэж тооцдог. Бас нэгэн жишээ бол бэлэвсэн эмэгтэй өрхийн тэргүүний үүрэг гүйцэтгэж байгаа боловч хамгийн том хүүгээ өрхийн тэргүүн гэж нэрлэх нь Монголчуудын дунд түгээмэл заншил юм.

боловсролын түвшин, ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөний байдлыг ядууралтай холбон авч үзэв.

2.4.1 Нас

Өрхийн тэргүүлэгчийн нас ядууралтай ямар хамааралтай байна вэ? Хүснэгт 2.4-д өрхийн тэргүүлэгчийн насыг таван бүлэгт хувааж харгалзах ядуурлын хэмжүүрүүдийг нь үзүүлэв.

Гучин наснаас доош насанд ядууралд өртөх нь бага байснаа 30-39 насны бүлэгт ядууралд өртөх нь нэмэгдэж, дөч гарахаар буурч байгаа ерөнхий дүр зураг хэвээр байна. Нийт өрхийн 12 хувь нь 30-аас доош насны залуу өрхийн тэргүүлэгчтэй, 57 хувь нь 30-49 насны тэргүүлэгчтэй,

үлдсэн 31 хувь нь 50-аас дээш насны тэргүүлэгчтэй өрхүүд байна. Ядуурлын хандлагад энэ бүлгүүдийн хэрэглээний зөрүү нөлөөлсөн байж болох талтай. Жишээ нь өрхийн тэргүүлэгч гучин нас гарах үед өрхийн ам бүлийн тоо шинэ хүүхдээр нэмэгдэх магадлалтай нь хүн ам зүйн ачаалал энэ насны тэргүүлэгчтэй өрхөд өндөр байгаагаас харагдаж байна. Түүнчлэн 60-аас дээш насны бүлэгт өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй байх магадлал нэмэгдсэн хэвээр байна.

2.4.2 Хүйс

Өрхийн тэргүүлэгчийн хүйсийн байдал ядууралтай ямар хамааралтай байгааг хүснэгт 2.5-оос харж болно.

Хүснэгт 2.5. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр

	Улсын хэмжээнд		Хот		Хөдөө	
	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй
Ядуурлын хамралтын хүрээ	24.4 (1.4)	21.0 (0.7)	24.6 (1.7)	17.3 (0.9)	24.0 (1.9)	26.7 (1.0)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.5)	5.0 (0.2)	6.8 (0.6)	4.4 (0.3)	5.6 (0.7)	5.9 (0.3)
Ядуурлын мэдрэмж	2.5 (0.2)	1.8 (0.1)	2.7 (0.3)	1.6 (0.1)	2.0 (0.3)	2.0 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	17.7	82.3	21.1	78.9	11.9	88.1
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	20.1	79.9	27.5	72.5	10.8	89.2
Өрхийн ам бүлийн тоо	2.7	3.8	2.8	3.8	2.4	3.8
Хүн ам зүйн ачаалал (%)	46.6	38.0	44.1	37.5	53.3	38.7
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	19.8	26.7	20.5	26.0	17.8	27.9
Өрхийн тэргүүлэгчийн нас	51.1	43.6	50.0	43.7	53.9	43.4
Гэрлэсэн, хамтран амьдардаг (%)	13.9	93.1	15.3	92.5	9.3	94.1
Бэлэвсэн, салсан, тусдаа амьдарч байгаа (%)	75.6	4.4	74.8	4.9	78.2	3.5

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

Нийт өрхийн 18 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй бөгөөд энэ үзүүлэлт хотод 21 хувь, хөдөөд 12 хувь байна. Хот суурин газарт болон хөдөөд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурал эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдтэй харьцуулахад бага байна. Харин энэ дүр зураг хөдөө нутагт эсрэгээрээ байна. Хөдөөд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх илүү ядууралд өртсөн байдалтай байна. Гэвч бид эрс өөр өөр бүтэцтэй өрхүүдийг үнэлж байгаа гэдгийг дээрх үр дүнг ашиглахдаа бодолцох ёстой. Өрхүүдийн хүн ам зүйн гурван онцлогийг үүнтэй холбогдуулан дурьдаж болох юм. Нэгдүгээрт, арван эмэгтэй тэргүүлэгч тутмын бараг найм нь бэлэвсэн, салсан эсвэл тусгаарласан байхад арван эрэгтэй тэргүүлэгч тутмын ес нь хань ижилтэй байна. Хоёрдугаарт, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн дундаж ам бүл нь 3 байхад эрэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн дундаж ам бүл 4 байна. Гуравдугаарт, Өрхийн тэргүүлэгчдийн хүйсэнд насны зөрүү тод ажиглагдаж байна. Эмэгтэй тэргүүлэгчийнхээс 8 насаар өндөр байна. Дээрх хүн ам зүйн онцлог шинжүүд өөрчлөлтгүйгээр хадгалагдсаар байна.

2.4.3 Боловсрол

Хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах нэг чухал хүчин зүйл нь боловсролын асуудал гэж үзэж болно. Боловсролгүй эсвэл бага боловсролтой хүн мэргэжлийн ур чадвар шаардахгүй ажил буюу цалин багатай ажил хийж улмаар хүндрэл, бэрхшээлд илүү өртөмтгий байдаг. Боловсролын түвшин өндөр байх нь ажилд орох боломжуудыг нэмж өгөхөөс гадна нийгэмдээ илүү идэвхитэй оролцоотой

байх зэрэг аж байдлын бусад чухал талуудыг ойлгоход тусалдаг. Хүснэгт 2.6-д ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшнээр харуулав. Боловсролын түвшин ба ядуурлын хоорондын хамаарлын талаар дүгнэлт хийхийн өмнө өрхийн тэргүүлэгчдийн боловсролын ерөнхий түвшинг харвал, улсын хэмжээгээр арван хүн бүрийн ес нь бүрэн бус дунд¹¹ болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн тэргүүлэгчтэй өрхөд, харин арван хүн тутмын нэг нь боловсролгүй эсвэл бага боловсролтой тэргүүлэгч бүхий өрхөд амьдарч байна. Судалгааны жил жилийн дүнгээс харахад өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын түвшин өндөр байх тусам тухайн өрх ядууралд өртөх магадлал багатай байдаг зүй тогтол ажиглагдаж байна. Өрхийн тэргүүлэгч бүрэн дундаас дээш боловсролтой байх нь ядууралд өртөх магадлалыг бууруулсаар байна. Бүрэн бус дунд боловсролтой тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг хүн амын ядуурлын хамралтын хүрээ 32.4 хувь байна. Бүрэн дундаас бага боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдийн хувьд ядуурлын хамралтын хүрээ ойролцоогоор 31-45 хувь, харин бүрэн дунд боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн хувьд 25 хувь, мэргэжлийн болон тусгай мэргэжлийн боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн хувьд ойролцоогоор 13-19 хувь байна. Харин өрхийн тэргүүлэгч нь дээд боловсролтой бол ядуурлын хамралтын хүрээ 5-6 хувь байна.

11. Бүрэн бус дунд боловсролын сургалтын жилийн тоо нь төгссөн оноос хамаарч байна. 1963 он хүртэл бүрэн бус дунд боловсрол нь 7 жилийн сургалттай байсан. 1964-2004 он хүртэл 8 жил, 2005 оноос 9 жилийн сургалттай болоод байна.

Хүснэгт 2.6. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр

	Улсын дундаж	Боловсролгүй	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	45.0 (2.3)	31.1 (1.8)	32.4 (1.2)	24.8 (1.2)	18.8 (1.5)	12.8 (1.6)	4.9 (1.0)	4.5 (0.7)	5.5 (4.3)	0.0 (0.0)
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	12.3 (1.0)	7.3 (0.6)	8.1 (0.4)	6.1 (0.4)	4.7 (0.5)	2.5 (0.4)	0.9 (0.2)	0.8 (0.2)	1.1 (1.0)	0.0 (0.0)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	4.8 (0.6)	2.6 (0.3)	3.0 (0.2)	2.2 (0.2)	1.7 (0.2)	0.8 (0.1)	0.3 (0.1)	0.2 (0.1)	0.2 (0.2)	0.0 (0.0)
Нэмэлт үзүүлэлтүүд:											
Хүн амын хувийн жин (%)	100.0	3.8	8.7	18.9	27.4	12.8	6.2	8.9	11.6	1.5	0.2
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	7.9	12.6	28.4	31.5	11.1	3.7	2.0	2.4	0.4	0.0
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.3	3.3	3.7	3.7	3.7	3.3	3.2	3.3	3.2	2.7
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	49.1	54.7	39.3	36.5	36.1	40.6	42.5	35.9	33.2	66.9
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.1	26.7	21.7	26.0	27.9	24.4	19.9	18.3	29.0	26.4	17.0
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	47.2	53.1	46.0	42.3	46.0	50.4	49.9	37.5	41.3	55.2
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	77.0	72.2	70.4	81.6	78.4	82.2	67.7	75.5	76.5	67.5	82.4

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

2.4.4 Ажил эрхлэлт

Өрхийн аж байдлыг тодорхойлогч өөр нэг чухал хүчин зүйл бол өрхийн гишүүдийн, түүний дотор өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрхэлж байгаа ажлын төрөл болно. Хүснэгт 2.7-д ядуурлын талаарх мэдээллийг ажиллах хүчний оролцоо, ажил эрхлэлтийн үндсэн салбараар харуулав.¹² Өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлж байгаа өрхөд амьдарч буй хүн амын 20.2 хувь нь ядуу байхад өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрхүүдийн 38.3 хувь нь ядуу байна.

Өрхийн тэргүүлэгч ямар салбарт ажил эрхэлж байгаа нь өрхийн амьжиргаанд ихээхэн нөлөөтэй байна. Өрхийн тэргүүлэгч нь үйлчилгээний салбарт ажиллаж байгаа өрхийн ядуурлын түвшин аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн салбарт өрхийн тэргүүлэгч нь ажилладаг өрхийнхөөс харьцангуй бага байна.

Ядуучуудын 28.2 хувь нь өрхийн тэргүүлэгч нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажилладаг, 19.7 хувь нь үйлчилгээний салбарт ажилладаг, 22.6 хувь нь аж үйлдвэрийн салбарт ажилладаг тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байгаа бөгөөд 14.0 хувь нь өрхийн тэргүүлэгч нь сүүлийн нэг жилийн хугацаанд огт ажил эрхлээгүй өрхөд тус тус амьдарч байна. Ядуурал болон ажил эрхлэлтийн хамаарлыг өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн салбараар нь судалж үзье. Хүснэгт 2.8-д өрхийн тэргүүлэгчийг мал малладаг, хувийн салбар, төсвийн байгууллага, мөн төрийн өмчийн аж ахуйн нэгжид ажил эрхэлдэгээр нь ялган харуулав. Түүнчлэн ажиллах хүчнээс гадуур байгаа хүн амыг тэтгэвэр, тэтгэмж авагч гэж тодорхойлсон. Энэ хүснэгтээс дараах дүгнэлтүүдийг хийж болно.

Өрхийн тэргүүлэгч нь бусад салбарт ажиллаж байгаа өрхүүдтэй харьцуулахад мал аж ахуй эрхэлдэг тэргүүлэгчтэй өрх ядууралд илүү их өртсөн хандлага хэвээр байна. Өрхийн тэргүүлэгч нь төрийн болон төсвийн байгууллага, мөн төрийн өмчит үйлдвэрт ажиллаж байгаа өрхүүдийн амьжиргааны түвшин хувийн хэвшилд ажиллагчдынхаас илүү сайн байна. Өрхийн тэргүүлэгч нь хувийн хэвшилд ажиллаж байгаа өрхүүдийн амьжиргааны түвшин мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргааны түвшнээс сайн байна. Өрхийн тэргүүлэгч нь ажил эрхлээгүй өрхүүдийн 38.3 хувь нь ядуу байна. Тэд нийт ядуучуудын 14.0 хувийг эзэлж байна. Дээрх өрхүүдээс ялгаатай нэг бүлэг байгаа нь өрхийн тэргүүлэгч нь хөдөлмөрийн зах зээлд оролцоогүй өрхүүд (тэтгэвэр, тэтгэмж авагчид) юм. Өрхийн тэргүүлэгч нь тэтгэвэр, тэтгэмж авдаг өрхүүдийн ядууралд хамрагдах магадлал нь улсын дунджаас бага байна. Гэвч өрхийн тэргүүлэгч нь тэтгэвэр авдаг бүлэг ядуучуудын 15.5 хувийг бүрдүүлж байна.

12. Хэрэв үгүй бол ажиллах хүчинд тооцогдохгүй. Хэрэв тухайн хүн сүүлийн жил ажил эрхэлсэн, ажил эрхлээгүй боловч байнгын ажилтэй, эсвэл ажилгүй бөгөөд ажил хайсан бол ажиллах хүчинд орно.

Хүснэгт 2.7. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар

	Ажилтай						Ажиллах хүчнээс гадуур
	Улсын дундаж	Нийт	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр	Үйлчилгээ	Ажилгүй	
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	20.2 (0.7)	27.9 (1.3)	24.0 (1.3)	12.8 (0.7)	38.3 (2.0)	20.0 (1.3)
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	4.6 (0.2)	5.8 (0.3)	6.0 (0.4)	2.9 (0.2)	11.8 (0.8)	5.1 (0.5)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	1.6 (0.1)	1.8 (0.1)	2.2 (0.2)	1.0 (0.1)	5.0 (0.4)	2.0 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	75.4	21.7	20.4	33.3	7.9	16.7
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	70.5	28.2	22.6	19.7	14.0	15.5
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.7	3.8	3.8	3.6	3.8	2.8
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	34.3	37.8	33.3	32.7	30.3	63.1
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.1	29.2	29.1	30.7	28.4	26.6	10.5
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	40.6	42.4	38.9	40.5	42.8	62.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	77.0	84.1	90.7	88.9	77.3	68.7	55.4

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алмааг хаалгана харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

Хүснэгт 2.8. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн салбараар

	Улсын дундаж	Ажил эрхэлдэг					Төрийн өмчит үйлдвэр	Бусад	Ажил эрхлээгүй	Тэтгэвэр, тэтгэмж авагч
		Малчин	Хувийн	Улсын	Төрийн өмчит үйлдвэр	Бусад				
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	26.6 (1.4)	19.7 (0.9)	12.8 (1.1)	12.7 (2.0)	22.1 (7.8)	38.3 (2.0)	20.0 (1.3)		
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	5.2 (0.4)	5.0 (0.3)	2.7 (0.3)	2.4 (0.4)	4.3 (1.7)	11.8 (0.8)	5.1 (0.5)		
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	1.6 (0.1)	1.8 (0.1)	0.9 (0.2)	0.7 (0.2)	1.3 (0.6)	5.0 (0.4)	2.0 (0.2)		
Нэмэлт үзүүлэлтүүд:										
Хүн амын хувийн жин (%)	100.0	19.3	41.5	11.7	2.5	0.3	7.9	16.7		
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	23.8	37.9	7.0	1.5	0.3	14.0	15.5		
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.8	3.7	3.6	3.6	3.5	3.8	2.8		
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	38.6	32.9	33.5	29.9	30.3	30.3	63.1		
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.1	29.3	29.4	29.0	27.7	24.5	26.6	10.5		
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	42.4	39.6	41.1	40.5	41.8	42.8	62.5		
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	77.0	91.0	83.6	75.2	84.1	90.5	68.7	55.4		

Санамж: Тэтгэмж авагч гэдэгт төрөөс ямар нэгэн төрлийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа бүх өрхийн тэргүүлэгчийг хамрууллаа.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

2.5 Хөрөнгө

Хөрөнгө өмчлөлийн байдал нь хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох бас нэг чухал хүчин зүйл билээ. Хөрөнгийн чадавхитай байх нь айл өрхийн эдийн засгийн тогтворгүй байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх улирлын өөрчлөлт, нөлөөллийг арилгах боломжийг олгоно. Хэрэв өрхийн үндсэн орлого ологч нь гэнэт ажилгүй болох, цас зуд, ган гачиг, усны үер зэрэг байгалийн гэнэтийн гамшиг тохиолдох зэрэг эрсдэлд орох үед өрхийн хэрэглээгээ хангахын тулд өрх нь үл хөдлөх хөрөнгөө ашигладаг. Тиймээс баялгийн энэ үзүүлэлтийг тухайн өрхийг эрсдэлд өртөхөөс хамгаалдаг даатгал гэж ойлгож болно.

2.5.1 Мал

Манай улсын хувьд мал сүрэг нь малчин айл өрхүүдийн амин чухал хөрөнгө, хөдөө аж ахуйн салбарын үндсэн үйлдвэрлэл болдог давхар ач холбогдолтой. Ажил эрхэлдэг арван хүн тутмын дөрөв орчим нь мал маллах болон мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой хөдөлмөр эрхэлж байна. Таван хошуу малын төрөл тус бүр нь өрхийн амьжиргаанд өөр өөрийн онцлогоос хамааран янз бүрийн хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал, ямаатай өрх нь ноолуурын бизнест оролцох, хонь эсвэл тэмээтэй байх нь ноосны худалдаа хийх, үхэр, адуутай байх нь мах, сүү, цагаан идээ, арьс, шир боловсруулах гэх мэт онцлог давуу боломжуудыг бий болгодог.

Малтай өрхийг таван хошуу малын төрөл болон хот, хөдөө, бүс, суурьшлаар Хүснэгт 2.9-д харуулав. Улсын хэмжээнд нийт хүн амын 31.7 хувь нь малчин байна. Үүнийг хот,

хөдөөгөөр авч үзвэл хотын хүн амын 7.6 хувь нь, хөдөөгийн хүн амын 73.8 хувь нь малчин байна. Хүн амын 21.7-27.2 хувь нь адуу, үхэр, хонь, ямаатай байхад 3.5 хувь нь тэмээтэй байна. Улаанбаатар хотод малтай өрхийн тоо хамгийн цөөн, харин хөдөө нутагт хүн амын 94.6 хувь нь аль нэг төрлийн малтай байна. Малтай өрхийг бүс нутгаар нь авч үзэхэд ийм эрс ялгаа байхгүй боловч Төвийн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад арай бага буюу хүн амын 38.0 хувь нь малчин байна. Харин Баруун бүсэд малтай өрх хамгийн өндөр буюу хүн амын 67.6 хувь, ялангуяа хонь, ямаа, тэмээ, адуутай хүн амын эзлэх хувь хэмжээ харьцангуй өндөр байна.

Малтай өрхүүдийг хооронд нь харьцуулан судлахын тулд малын тоог нэгтгэн бодод шилжүүлэн тооцов. Ингэхэд малчдын дунд бодод шилжүүлснээр нэг хүнд ногдох малын тоо 15 бод буюу 15 адуутай тэнцүү байна.¹³ (Хүснэгт 2.9) Малтай нэг хүнд ногдох малын дундаж тоо хөдөөд хотынхоос хоёр дахин их байна. Бүс нутгаар авч үзэхэд Төв, Зүүн бүсүүдэд нэг хүнд ногдох малын дундаж тоо хамгийн олон, харин малчин хүн амын тоо нь Баруун, Хангайн бүсүүдтэй харьцуулахад цөөн байна. Баруун бүсэд таван хошуу мал болон малтай хүний хувийн жин хамгийн их боловч нэг хүнд ногдох малын дундаж тоо хамгийн бага байна. Эцэст нь ядуу олон хүн мал маллаж байгаа ч тэдний өмчилж байгаа малын дундаж тоо нь ядуу бус хүн амын малын дундаж тооноос илт цөөн байна. Тухайлбал, хонь, ямааг ядуу олон хүн маллаж байгаа ч малын тоо нь харьцангуй бага байна.

13. Малын тоог нэгтгэн тоолохын тулд бодод шилжүүлэх коэффициентийг хэрэглэв. Малын бодод шилжүүлэх коэффициент: 1 бод=1 адуу=1 үхэр=0.67 тэмээ=6 хонь=8 ямаа

Хүснэгт 2.9. Мал аж ахуй эрхлэлт

	Үхэр		Адуу		Тэмээ		Хонь		Ямаа		Бод	
	Малчид (%)	Малын дундаж тоо	Малчид (%)	Малын дундаж тоо	Малчид (%)	Малын дундаж тоо	Малчид (%)	Малын дундаж тоо	Малчид (%)	Малын дундаж тоо	Малчид (%)	Малын дундаж тоо
Улсын дундаж	24.7	4.7	21.7	4.6	3.5	3.0	25.8	32.2	27.2	30.1	31.7	14.9
Хот	5.3	3.4	3.0	4.4	0.2	2.7	4.3	20.4	4.8	17.1	7.6	7.5
Хөдөө	58.6	4.9	54.6	4.6	9.4	3.0	63.5	33.6	66.5	31.8	73.8	16.2
Улаанбаатар	2.5	4.2	1.2	5.7	0.0	0.5	1.1	23.7	1.1	19.2	3.1	7.7
Аймгийн төв	10.9	3.1	6.7	4.0	0.5	3.0	10.9	19.7	12.4	16.7	16.8	7.5
Сумын төв	38.5	3.5	27.5	3.4	3.2	2.6	37.3	21.0	40.7	19.5	50.9	9.2
Хөдөө нутаг	76.8	5.5	79.1	4.9	15.0	3.0	87.2	38.5	89.9	36.8	94.6	19.6
Баруун	52.8	2.8	49.5	2.3	11.3	1.6	56.6	23.1	62.6	25.1	67.6	10.4
Хангай	41.9	5.6	39.0	4.4	2.5	3.3	48.3	30.0	49.7	29.1	54.9	15.3
Төв а/	27.4	5.1	22.4	7.1	5.3	6.5	29.2	44.1	30.5	42.5	38.0	19.1
Зүүн	45.3	6.7	38.3	7.6	6.7	1.5	41.1	48.0	41.7	31.0	50.5	21.8
Ядуу бус	24.5	5.3	21.2	5.2	3.5	3.4	25.4	37.1	26.3	34.0	30.8	17.1
Ядуу	25.2	2.7	23.6	2.4	3.7	1.6	27.5	16.0	30.7	18.1	34.8	7.9

а/ Улаанбаатар хотыг оруулаагүй.

Санамж: Малын тоог бодод шилжүүлсэн. Ингэхдээ малыг адуутай адилтгаж тооцдог.


Нэг бод нь нэг адуу, нэг үхэр, 0.67 тэмээ, 6 хонь буюу 8 ямаатай тэнцүү гэж тооцдог. Сарлагийг үхэрт тооцсон. Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

Малажахуйэрхлэлт, амьжиргааны түвшний хооронд ямар хамаарал байна вэ? Хүснэгт 2.10-т ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг мал аж ахуй эрхэлдэг өрхүүдээр, хот, хөдөөгөөр харьцуулж харуулав. Хөдөөд хүн амын 73.8 хувь нь малчин, 26.2 хувь нь малчин бус, харин хотод хүн амын 7.6 хувь нь малчин, 92.4 хувь нь малчин бус байна. Улсын дунджаар харвал малчин өрх малчин бус өрхөөс илүү ядууралд өртсөн байна. Тухайлбал, малчин бус өрхийн 20.6 хувь нь ядуу байхад малчин өрхийн 23.7 хувь нь ядуу байна. Харин хот, хөдөөд ялгаагүй мал аж ахуй эрхэлж байгаа хүн амыг малчин бус хүн амтай харьцуулахад ядууралд өртөх нь бага, амьжиргаа сайтай болсон байна. Энэ хандлага 2012 оныхоос өөрчлөгджээ. 2012 онд хот, хөдөөд аль алинд нь малчин өрх малчин бус өрхөөс ядуу байсан байна. Эндээс

дүгнэхэд, сүүлийн жилүүдэд малчдын амьжиргаа болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлого үр дүнгээ өгч буйг харуулж байж болох юм.

Малын тоо толгойн нөлөө хэр байна вэ? Зураг 2.3-т нэг малчинд ногдох малын тооноос ядуурлын хамралтын хүрээ хэрхэн хамаарч байгааг харуулав.

Зураг 2.3. Ядуурал ба малын тоо



Хүснэгт 2.10. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Малчин бус	Малчин	Малчин бус	Малчин	Малчин бус	Малчин
Ядуурлын хамралтын хүрээ	20.6 (0.8)	23.7 (1.0)	19.0 (0.9)	17.2 (1.7)	30.6 (1.5)	24.9 (1.1)
Ядуурлын гүнзгийрэлт	5.4 (0.3)	4.9 (0.3)	5.0 (0.3)	4.0 (0.7)	8.2 (0.6)	5.0 (0.3)
Ядуурлын мэдрэмж	2.1 (0.1)	1.5 (0.1)	1.9 (0.1)	1.4 (0.3)	3.2 (0.3)	1.6 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	68.3	31.7	92.4	7.6	26.2	73.8
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	65.2	34.8	93.1	6.9	30.3	69.7
Өрхийн ам бүлийн тоо	3.4	3.8	3.5	3.8	3.0	3.7
Хүн ам зүйн ачаалал (%)	39.4	41.2	39.0	42.7	42.0	41.0
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	24.2	27.4	24.4	26.5	22.8	27.5
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.5	44.9	45.2	46.5	46.8	44.6
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	72.6	87.5	72.9	86.2	70.9	87.8

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

Хөдөөд нэг хүнд ногдох малын тоо өсөхөд ядуурал эрчимтэйгээр жигд буурч байгаа нь нэг хүнд ногдох малын тоо болон тухайн өрхийн амьжиргааны түвшний хооронд шууд хамааралтай байгааг харуулж байна. Харин хотод нэг хүнд ногдох малын тоо 15-аас ихсэх тутам тухайн өрхийн амьжиргаанд ямар нэг нөлөө үзүүлэхгүйгээр ядуурлын хамралтын хувь тогтмол хандлагатай байна.

2.5.2 Газар

Газар нь өрхүүдийн, ялангуяа хөдөө аж ахуй эрхэлдэг өрхүүдийн хувьд хамгийн чухал хөрөнгийн нэг. Манай улсад мал аж ахуйтай харьцуулахад газар тариалангийн хөгжил хязгаарлагдмал байдаг. Учир нь уур амьсгалын эрс тэс нөхцөл,

цаг агаарын хүндрэл, хөрсний чанар муу, усны нөөц хязгаарлагдмал, өрхүүд газар тариаланг уламжлан эрхэлж байгаагүй зэрэг шалтгаан нь газар тариалангийн хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Өрхийн судалгааны дүнгээр хүн амын бараг тал хувь нь тариалангийн газар өмчилдөг буюу эсвэл тариалангийн зорилгоор газар ашигладаг байна. Хот, хөдөөд энэ үзүүлэлт ойролцоо байна. Улсын хэмжээгээр газар эзэмшигч хүн амын амьжиргаа нь газар эзэмшдэггүй хүн амаас дээгүүр байна. Газар өмчлөлийг хот, хөдөөгөөр авч үзвэл хотод хүн амын 46.0 хувь нь, хөдөөд хүн амын 47.2 хувь нь газартай байна. Хөдөөд газар өмчилдөггүй хүн амын ядуурал өндөр, харин хотод газар өмчилдөг өрхийн ядуурал өндөр байна.

Хүснэгт 2.11. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, газар өмчлөлийн байдлаар

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Газаргүй	Газартай	Газаргүй	Газартай	Газаргүй	Газартай
Ядуурлын хамралтын хүрээ	23.1 (0.9)	19.9 (0.9)	17.8 (1.0)	20.1 (1.2)	32.5 (1.4)	19.5 (1.1)
Ядуурлын гүнзгийрэлт	5.9 (0.3)	4.4 (0.3)	5.1 (0.4)	4.7 (0.4)	7.5 (0.4)	4.0 (0.3)
Ядуурлын мэдрэмж	2.2 (0.1)	1.5 (0.1)	2.0 (0.2)	1.6 (0.2)	2.6 (0.2)	1.3 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	53.5	46.5	54.0	46.0	52.8	47.2
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	57.2	42.8	50.9	49.1	65.0	35.0
Өрхийн ам бүлийн тоо	3.3	3.8	3.3	3.8	3.3	3.8
Хүн ам зүйн ачаалал (%)	40.2	39.6	39.3	39.1	41.9	40.5
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	24.8	25.6	24.5	24.6	25.2	27.3
Өрхийн тэргүүлэгчийн нас	44.3	46.6	44.1	47.0	44.7	45.9
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	74.1	80.9	71.0	77.8	79.9	86.2

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

2.5.3 Хадгаламж

Өрхийн баялгийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь санхүүгийн хөрөнгө билээ. Хэрэв орлого нь зарлагаа давж байвал хүмүүс хуримтлуулдаг, харин өдөр тутмын хэрэгцээнд дөнгөж хүрэлцэх төдий орлоготой бол хадгаламж үүсгэх боломжгүй нь тодорхой юм. Манай орны хүн амын 35 хувь нь санхүүгийн байгууллагад мөнгөн хадгаламжтай өрхөд амьдарч байна.¹⁴ Суурьшлаар авч үзвэл хот суурин газарт хүн амын 35 хувь нь, хөдөөд 34 хувь нь хадгаламжтай байна.

Энэ нь хүмүүс хаана амьдарч байгаагаас хамаарахгүйгээр хадгаламжинд мөнгө хуримтлуулах сонирхолтой болсныг харуулж байна. Хот, хөдөө аль алинд нь хадгаламжтай өрхийн ядуурлын хамралтын хүрээ бага, хадгаламжгүй өрхийн ядуурлын хамралтын хүрээ их байгаа нь энэ хоёр үзүүлэлт шууд хамааралтай байгааг илэрхийлж байна. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд хадгаламж эзэмшигчдийн ядуурлын хамралтын хүрээ нь хадгаламжгүй хүмүүсийнхээс бараг 3 дахин бага байгаа бол сумын төв болон хөдөөд ойролцоогоор 2 дахин бага байна.

Хүснэгт 2.12. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламжийн байдлаар

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Хадгаламжгүй	Хадгаламжтай	Хадгаламжгүй	Хадгаламжтай	Хадгаламжгүй	Хадгаламжтай
Ядуурлын хамралтын хүрээ	26.4	12.6	23.9	9.5	30.6	18.1
	(0.8)	(0.7)	(1.1)	(0.9)	(1.1)	(1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	6.6	2.7	6.5	2.0	6.8	4.0
	(0.3)	(0.2)	(0.4)	(0.2)	(0.3)	(0.4)
Ядуурлын мэдрэмж	2.5	0.9	2.5	0.6	2.3	1.3
	(0.1)	(0.1)	(0.2)	(0.1)	(0.2)	(0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	65.3	34.7	64.8	35.2	66.2	33.8
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	79.8	20.2	82.2	17.8	76.8	23.2
Өрхийн ам бүлийн тоо	3.4	3.7	3.5	3.6	3.4	3.8
Хүн ам зүйн ачаалал (%)	40.1	39.8	39.7	38.3	40.6	42.8
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	23.0	29.6	22.7	28.2	23.3	32.2
Өрхийн тэргүүлэгчийн нас	46.5	43.0	46.5	43.0	46.3	42.9
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	74.7	81.8	71.5	78.5	80.1	88.1
<i>Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав. Эх сурвалж: ӨНЭЭС 2014.</i>						

14. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар өрхийг хадгаламжтай эсэхийг асуудаг. Ямар төрлийн хадгаламж, хэдий хэмжээний мөнгө байгаа талаар асуудаггүй.

2.5.4 Зээл

Хүн амын дунд зээл авах хандлага жил ирэх тусам нэмэгдэж байгаа ба энэ нь сүүлийн жилүүдэд өрхийн санхүүгийн чухал эх үүсвэрийн нэг болсоор байна. Монгол Улсын нийт хүн амын бараг тал хувь нь ямар нэг төрлийн зээлтэй байгаа ба зээлийг төрлөөр нь авч үзвэл давхардсан тоогоор хүн амын 40 хувь нь цалингийн зээлтэй, 19 хувь нь малчны зээлтэй, 15 хувь нь тэтгэврийн зээлтэй, 9 хувь нь орон сууц, бизнесийн зээлтэй, 7 хувь нь өрхийн хэрэглээний зээлтэй, 13 хувь нь бусад төрлийн зээлтэй байна.

Нийт зээлтэй хүн амын 18 хувь, зээлгүй хүн амын 25 хувь нь ядуу байна. Тархалтаар нь авч үзвэл ядуу хүн амын 38 хувь зээлтэй, 62 хувь нь зээлгүй байна. Өрхийн хэрэглээний болон малчны зээлтэй хүн амын хувьд ядуурлын хамралт улсын дунджаас өндөр байна. Өрхийн хэрэглээний зээлтэй хүн амын 30 хувь нь ядуу байгаа хэдий ч энэ төрлийн зээлтэй хүн ам, нийт хүн амын 7 хувь, ядуу хүн амын 11 хувь байна. Харин орон сууцны зээлтэй хүн ам, нийт хүн амын 9 хувь, ядуу хүн амын 1 хувь байна. Цалингийн зээлтэй хүмүүс нийт хүн амын 40 хувь, ядуу хүн амын хамгийн их хувийг буюу 33 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2.13. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, зээлийн төрлөөр

	Улсын дундаж	Зээлтэй								Зээлгүй
		Нийт	Цалин-гийн	Тэтгэв-рийн	Орон сууцны	Өрхийн хэрэглээний	Малчны	Бизнесийн	Бусад	
Ядуурлын хамралтын хүрээ	21.6 (0.7)	18.1 (0.7)	14.8 (0.9)	20.9 (1.8)	2.3 (0.9)	29.5 (3.1)	23.5 (1.8)	11.2 (1.8)	21.3 (1.8)	24.5 (0.9)
Ядуурлын гүнзгийрэлт	5.2 (0.2)	3.8 (0.2)	2.9 (0.2)	4.3 (0.5)	0.3 (0.2)	6.3 (1.0)	4.8 (0.5)	1.8 (0.4)	5.6 (0.6)	6.5 (0.3)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.1)	1.2 (0.1)	0.9 (0.1)	1.4 (0.2)	0.1 (0.1)	2.2 (0.5)	1.5 (0.2)	0.5 (0.1)	2.2 (0.3)	2.5 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:										
Хүн амын хувийн жин (%)	100.0	45.5	40.2	14.6	9.3	6.5	19.4	9.1	13.1	54.5
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	38.3	32.8	16.8	1.2	10.5	25.1	5.6	15.4	61.7
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.8	3.9	3.0	3.7	4.1	4.2	4.0	4.0	3.3
Хүн ам зүйн ачаалал (%)	40.0	39.7	33.6	63.7	33.5	36.4	38.0	33.3	35.6	40.2
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.1	27.1	30.2	10.5	29.4	31.0	32.2	29.2	31.0	23.7
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.3	44.8	41.5	61.2	39.0	42.2	41.9	43.3	41.6	45.7
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	77.0	79.5	83.2	57.3	79.3	83.0	92.4	84.2	79.3	75.2

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЗС 2014.

2.6 Сууц

Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох гол үзүүлэлтийн нэг нь тухайн өрх, хүний эзэмшиж байгаа сууцны төрөл болон дэд бүтцийн үндсэн үйлчилгээнд хамрагдсан байдал юм. Өрхийн сууцны нөхцөл, ахуйн үйлчилгээ сайжирснаар өрх, хүн ам нь эмзэг байдлаас гарах, цаашлаад амьжиргаагаа дээшлүүлэх боломж нэмэгдэнэ. Дэд бүтцийн хөгжил сайн байх нь өрхийн гишүүдийн тухтай амьдрах нөхцөл, бүтээмжийг нэмэгдүүлэх бололцоог олгодог. Тухайлбал, төвлөрсөн усан хангамжийн системтэй холбогдож ундны шаардлага хангасан ус хэрэглэж байгаа өрх, хүн амыг гэрээсээ хагас цаг гаруй явж хэрэглээний усаа авч байгаа өрх, хүн амтай харьцуулахад мэдээж ахуйн давуутай нөхцөлд амьдарч байна. Энд өрх, хүн амын сууцны төрөл болон тэдний дэд бүтцийн үндсэн үйлчилгээг хүртэж байгаа байдлын талаар авч үзнэ.

2.6.1 Сууцны төрөл

Монгол улсын хүн амын сууцны хамгийн нийтлэг нэг төрөл бол гэр юм. Нийт хүн амын 42.1 хувь нь гэрт, 34.0 хувь нь сууцны тусдаа байшинд, 22.0 хувь нь нийтийн орон сууцны байшин доторх сууцанд (цаашид, нийтийн тохилог сууц гэнэ) амьдарч байна. Суурьшлаар нь авч үзэхэд хотын хүн амын 36.5 хувь нь сууцны тусдаа байшинд, 28.0 хувь нь гэрт, мөн 33.1 хувь нийтийн тохилог сууцанд амьдарч байна. Харин хөдөөгийн хүн амын 66.7 хувь нь гэрт, 29.6 хувь нь сууцны тусдаа байшинд, 2.5 хувь нь нийтийн тохилог сууцанд амьдарч байна. Хүснэгт 2.14-т ядуурал сууцны

төрөлтэй ямар хамааралтай байгааг харуулав. Ядуурлын түвшин гэрт амьдран суугчдын дунд харьцангуй өндөр, сууцны тусдаа байшинд амьдрагчдын хувьд үүнээс арай бага, харин нийтийн тохилог сууцанд амьдрагчдын дунд хамгийн бага байна. Хот, хөдөөд энэ чиг хандлага адил байсаар байна.

2014 оны судалгааны дүнгээр хотод гэрт амьдрагчдын 38.6 хувь, хөдөөд 29.6 хувь нь ядуу байна. Хотод нийтийн тохилог сууцанд амьдрагчдын 1.5 хувь нь ядуу байхад хөдөөд нийтийн тохилог сууцанд суугчдын 8.1 хувь нь ядуу байна. Хотод гэрт амьдардаг өрх хүн амын 28.0 хувийг эзэлж байгаа ч ядуучуудын 57.4 хувийг бүрдүүлж байна. Харин тохилог сууцанд амьдарч байгаа хүн ам 33.1 хувийг эзэлж байгаа боловч дөнгөж 2.7 хувь нь л ядуу байна. Хөдөөд сууцны төрөл тус бүрд ядуучуудын тархалт нь нийт хүн амын тархалттай ойролцоо байна.

Хүснэгт 2.14. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр

	Улсын дундаж						Хот						Хөдөө									
	Гэр		Тохилог сууц		Бусад		Гэр		Тохилог сууц		Байшин		Бусад		Гэр		Тохилог сууц		Байшин		Бусад	
Ядуурлын хамралтын хүрээ	33.4 (1.0)	1.8 (0.4)	19.5 (0.9)	25.4 (3.2)	38.6 (1.5)	1.5 (0.4)	18.9 (1.1)	27.0 (3.9)	29.6 (1.2)	8.1 (2.3)	21.0 (1.5)	20.4 (4.4)										
Ядуурлын гүнзгийрэлт	8.6 (0.4)	0.3 (0.1)	4.2 (0.3)	7.1 (1.3)	11.3 (0.6)	0.2 (0.1)	4.1 (0.3)	7.6 (1.6)	6.7 (0.4)	1.5 (0.5)	4.4 (0.5)	5.4 (1.5)										
Ядуурлын мэдрэмж	3.3 (0.2)	0.1 (0.0)	1.4 (0.1)	2.6 (0.7)	4.6 (0.3)	0.1 (0.0)	1.3 (0.1)	2.8 (0.9)	2.3 (0.2)	0.4 (0.2)	1.4 (0.2)	1.8 (0.6)										
Нэмэлт үзүүлэлтүүд:																						
Хүн амын хувийн жин (%)	42.1	22.0	34.0	1.9	28.0	33.1	36.5	2.4	66.7	2.5	29.6	1.2										
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	65.1	1.8	30.8	2.3	57.4	2.7	36.5	3.4	74.8	0.8	23.5	0.9										
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.3	3.7	3.3	3.6	3.3	3.7	3.5	3.5	3.1	3.7	2.9										
Хүн ам зүйн ачаалал (%)	41.6	36.7	40.4	36.3	42.1	36.6	39.8	38.0	41.3	39.8	41.8	31.7										
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	26.5	22.8	25.2	22.5	27.0	22.9	24.5	24.1	26.1	22.2	26.8	18.2										
Өрхийн тэргүүлэгчийн нас	44.9	44.1	46.7	45.3	45.2	44.0	46.8	45.2	44.7	45.5	46.4	45.7										
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	78.2	75.0	77.7	65.9	70.8	74.8	76.0	63.9	83.5	79.9	81.4	71.3										

Санамж: Бусад сууцанд оюутны дотуур байр, компанийн ажилчдын байр болон айл, өрхөд зориулаагүй бусад байшингуудыг оруулав. Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

2.6.2 Дэд бүтцийн үйлчилгээ

Хүн амыг сайжруулсан усан хангамж, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, цахилгаан, эрчим хүч зэрэг дэд бүтцийн үйлчилгээгээр хангаснаар хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ.¹⁵ Шаардлага хангаагүй усан хангамж болон ариун цэврийн байгууламж нь хүн амын эрүүл мэндэд шууд нөлөөлж, өвчлөл, түүний дэгдэлтийг нэмэгдүүлж, шаардлагагүй зардлыг буй болгон хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлнө. Цахилгаан, эрчим хүчний дутагдал нь хүн амын боловсрол, хөрөнгө оруулалтанд сөрөг нөлөө үзүүлнэ. Тэгвэл аж байдлын энэ үзүүлэлтүүд ямар байна вэ?

Ядуурал нь дэд бүтцийн үндсэн үйлчилгээнүүдийн хүртээмжээс хэрхэн хамаарч байгааг Хүснэгт 2.15 ба 2.16-д үзүүлэв. Судалгааны дүнгээр хүн амын 70.4 хувь нь сайжруулсан усан хангамжтай, 79.4 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай, 81.0 хувь нь цахилгаан эрчим хүчээр хангагдсан ба нийт хүн амын 63.8 хувь нь дээрх гурван үйлчилгээг бүгдийг нь хүртэж байна. Энэ нь 2012 оноос нэлээн сайжирсан үзүүлэлт болсон байна. Эдгээр үйлчилгээний хүртээмж нь

хотод хөдөөгийнхөөс өндөр байна. Жишээ нь хотын хүн амын 95.1 хувь нь, хөдөөгийн хүн амын 51.8 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байна. Хотын хүн ам үндсэндээ цахилгаан эрчим хүчээр хангагдсан байхад хөдөөд хүн амын 49.0 хувь нь л цахилгаан эрчим хүчний үйлчилгээг авч байна.

Дээр дурьдсан хоёр хүснэгтэнд харуулсан мэдээлэлд нарны эрчим хүчний хэрэглээ багтаагүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Засгийн газраас хямдруулсан үнэ бүхий нарны зайн эх үүсвэрээр малчдыг хангах бодлогыг хэрэгжүүлж сүүлийн хэдэн жил ихээхэн амжилт олсон. Хэдийгээр энэ төрлийн эрчим хүч нь цахилгааныг бүрэн орлохгүй ч одоо хөдөөгийн хүн ам нарны эрчим хүч эсвэл цахилгааны эрчим хүчээр бараг бүрэн хангагдсан байна. Сайжруулсан усан хангамж, ариун цэврийн байгууламж, цахилгаан гэсэн гурван үндсэн үйлчилгээг бүгдийг нь хотын хүн амын 81.8 хувь нь хүртэж байхад хөдөөд зөвхөн 32.3 хувь нь хүртэж байна. Үүний зэрэгцээ эдгээр үйлчилгээний чанарын асуудлыг анхаарах хэрэгтэй. Хэдийгээр энэ судалгаагаар үйлчилгээний чанарын мэдээллийг аваагүй ч хотынхон ерөнхийдөө хөдөөгийнхнөөс илүү чанартай үйлчилгээг хүртэж байна гэж үзэж болох юм.

15. Сайжруулсан усан хангамж гэдэг нь төвлөрсөн усан хангамжинд холбогдсон буюу хамгаалалттай худгаас усаа авч хэрэглэдэг байх (хамгаалалтгүй худаг, гол, булаг, цас мөсний ус хэрэглэдэг бол үүнд орохгүй) гэж тодорхойлсон. Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж гэдэг нь хувийн болон дундын /нийтийн бус/ бохир зайлуулах шугам, нүхтэй байхыг хэлнэ. Энэ нь энгийн болон төвлөрсөн бохирын сүлжээ зэрэг байж болно.

Хүснэгт 2.15. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр

	а/ Сайжруулсан усан хангамж		б/ Ариун цэврийн байгууламж		Цахилгаан		Бүгд	
	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм
	(%)	(%)	(%)	(%)	(%)	(%)	(%)	(%)
Ядуурлын хамралтын хүрээ	28.7 (1.2)	18.6 (0.7)	30.1 (1.4)	19.4 (0.7)	27.9 (1.4)	20.1 (0.7)	29.1 (1.1)	17.3 (0.7)
Ядуурлын гүнзгийрэлт	6.8 (0.4)	4.6 (0.2)	6.9 (0.4)	4.8 (0.2)	6.0 (0.4)	5.1 (0.2)	6.9 (0.3)	4.3 (0.2)
Ядуурлын мэдрэмж	2.4 (0.2)	1.7 (0.1)	2.4 (0.2)	1.8 (0.1)	2.0 (0.2)	1.9 (0.1)	2.5 (0.2)	1.6 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:								
Хүн амын хувийн жин (%)	29.6	70.4	20.6	79.4	19.0	81.0	36.2	63.8
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	39.4	60.6	28.8	71.2	24.5	75.5	48.8	51.2
Өрхийн ам бүлийн тоо	3.6	3.5	3.6	3.5	3.6	3.5	3.6	3.5
Хүн ам зүйн ачаалал (%)	41.0	39.6	40.5	39.8	39.8	40.0	41.1	39.4
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	26.3	24.7	27.1	24.7	26.5	24.8	26.5	24.4
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.2	45.4	44.2	45.6	44.2	45.6	45.0	45.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	81.9	75.1	85.6	74.9	87.9	74.6	82.1	74.3

а/ Сайжруулсан усан хангамжтай буюу төвлөрсөн усан хангамж, хамгаалалттай худаг, булаг зэргээс ус авдаг хүн амын хувийн жин юм. Сайжруулаагүй усан хангамж гэдэгт зөөврийн ус, хамгаалалтгүй худаг, булгийн ус орно.

б/ Сувагжуулалт гэдэгт хог гадагшлуулах (хувийн болон нийтийн) бохирын цооног/шугамтай өрхүүдийн хувийн жинг оруулан тооцно. Энэ нь сууцны гаднах бие засах газраас эхлээд бохир усны сүлжээнд холбогдсон бие засах газар байж болно.

Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.


Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

Ус, ариун цэврийн байгууламж болон цахилгаан хангамжийн үйлчилгээг хүртэх боломжгүй хүн амын амьжиргааны түвшин тэдгээр үйлчилгээг хүртэж буй хүн амынхаас доогуур байна. Энэ гурван үйлчилгээг бүгдийг нь хүртдэг хүн амын 17.3 хувь нь ядуу байхад үйлчилгээг хүртдэггүй хүн амын 29.1 хувь нь ядуу байна. Энэ ерөнхий чиг хандлага хот, хөдөөгийн суурьшилд хоёуланд нь ажиглагдаж байна.

Зураг 2.4-г дэд бүтцийн үйлчилгээний хүртээмжийг хүн амын

ядуурлын байдлаар харуулав. Ядуу бус хүн амын дунд сайжруулсан усан хангамж, ариун цэврийн байгууламж болон цахилгаан эрчим хүчний үйлчилгээний хүртээмж ядуу хүн амтай харьцуулахад илүү байгаа бөгөөд үйлчилгээнүүдийг хамтад нь хүртэж байгаагаар нь нарийвчлан үзвэл ялгаа нь улам нэмэгдэж байна. Энэ дүр зураг хот, хөдөөд хоёуланд нь ажиглагдаж байна. Гэхдээ ядуу ба ядуу бус хүн амын эдгээр үйлчилгээг хүртэж байгаа байдал нь хөдөөд нэлээн бага байна.

Зураг 2.4. Дэд бүтцийн үйлчилгээний хүртээмж, ядуурлын байдлаар



Эх сурвалж: ӨНЭЭС 2014

Хүснэгт 2.16. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр, хот, хөдөөгөөр

	а/ Сайжруулсан усан хангамж			б/ Ариун цэврийн байгууламж			Цахилгаан			Бүгд						
	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот				
	Үгүй	Тийм		Үгүй	Тийм		Үгүй	Тийм		Үгүй	Тийм					
Ядуурлын хамралтын хүрээ	29.8	17.0	28.2	24.0	40.1	17.8	28.3	24.6	34.3	18.7	27.7	25.0	31.5	16.0	28.0	23.0
	2.7	0.9	1.3	1.3	3.3	0.9	1.5	1.1	6.6	0.9	1.5	1.1	2.3	0.8	1.2	1.4
Ядуурлын гүнзгийрэлт	8.2	4.4	6.1	5.5	11.2	4.6	6.2	5.5	11.7	4.9	5.8	5.8	8.5	4.1	6.1	5.2
	0.9	0.3	0.4	0.4	1.3	0.3	0.4	0.4	3.3	0.3	0.4	0.4	0.8	0.3	0.3	0.5
Ядуурлын мэдрэмж	3.2	1.6	2.1	1.9	4.4	1.7	2.0	1.9	5.1	1.8	1.9	2.1	3.3	1.5	2.1	1.8
	0.4	0.1	0.2	0.2	0.7	0.1	0.2	0.2	1.9	0.1	0.2	0.2	0.4	0.1	0.2	0.3
Нэмэлт үзүүлэлтүүд:																
Хүн амын хувийн жин (%)	14.3	85.7	56.3	43.7	4.9	95.1	48.2	51.8	0.7	99.3	51.0	49.0	18.2	81.8	67.7	32.3
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	22.7	77.3	60.3	39.7	10.4	89.6	51.8	48.2	1.3	98.7	53.6	46.4	30.4	69.6	71.8	28.2
Өрхийн ам бүлийн тоо	3.6	3.5	3.6	3.4	3.6	3.5	3.6	3.4	3.0	3.5	3.7	3.4	3.6	3.5	3.6	3.3
Хүн ам зүйн ачаалал (%)	42.1	38.8	40.5	42.2	40.7	39.2	40.5	42.0	41.6	39.2	39.7	42.8	41.5	38.7	40.8	42.1
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.7	24.4	26.5	25.6	27.6	24.4	27.0	25.4	17.4	24.6	26.8	25.5	26.1	24.3	26.7	24.9
Өрхийн тэргүүлэгчийн нас	46.2	45.2	44.7	45.9	43.9	45.4	44.2	46.1	50.0	45.3	44.0	46.4	45.7	45.3	44.7	46.4
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	74.3	73.8	85.2	79.4	75.2	73.8	87.4	78.4	81.4	73.8	88.1	77.3	74.6	73.7	85.7	76.6

а/ Сайжруулсан усан хангамжтай буюу төвлөрсөн усан хангамж, хамгаалалттай худаг, булаг зэргээс ус авдаг хүн амын хувийн жин юм.

Сайжруулаагүй усан хангамж гэдэгт зөөврийн ус, хамгаалалтгүй худаг, булгийн ус орно.

б/ Сувагжуулалт гэдэгт хог гадагшлуулах (хувийн болон нийтийн) бохирын цооног/шугамтай өрхүүдийн хувийн жинг оруулан тооцно.

Энэ нь сууцны гаднах бие засах газраас эхлээд бохир усны сүлжээнд холбогдсон бие засах газар байж болно.

Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

2.7 Нийгмийн хамгаалал

Нийгмийн хамгаалал нь ядуурлыг бууруулахад чухал үүрэгтэй бөгөөд эдийн засаг, нийгэм, хүрээлэн байгаа байгаль орчны нөхцөл байдлаас шалтгаалан хувь хүн, өрхөд учрах сөрөг нөлөөллийг багасгах зорилготой. Эдгээр сөрөг нөлөөлөл нь байнгын (хөгжлийн бэрхшээл, хөдөлмөрийн чадваргүй) юмуу түр зуурын болон ажилгүйдлийн шинж чанартай байж болох юм. Мөн улсын хэмжээнд тохиолдсон, нийгмийн томоохон бүлэг хэсэг өртсөн байгалийн гамшиг, бэрхшээл (зуд, ган, үер, түймэр гэх мэт) болон тэжээгчээ алдах зэргээр зөвхөн тухайн өрхөд хамаарахаар ч байж болно. Гэхдээ тухайн тохиолдол бүрт авах хариу арга хэмжээ нь өрх бүрт өөр өөр байна.

Нийгмийн хамгааллын үндсэн 2 сүлжээ байдаг. Нийгмийн хамгааллын албан бус сүлжээ нь уламжлалт буюу албан бус арга замаар тухайн орон нутгийн хүмүүс, танил тал болон өрхийн гишүүдийн дэмжлэгт тулгуурласан, бусдаас авсан бэлэг, тусламж, хандив хэлбэрээр тодорхойлогддог. Харин нийгмийн хамгааллын албан сүлжээ нь нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст төрөөс туслах, хамгаалахад чиглэгддэг. Нийгмийн хамгааллын албан бус сүлжээ буюу албан бус, хувийн тусламж ч түгээмэл байна. Тухайлбал, малчид малаа бэлэглэх гэх мэт хувийн шилжүүлгийн хэлбэрийг ашиглаж байна.

Монгол улсын хувьд нийгмийн хамгааллын албан сүлжээ нь нэлээд өргөн хүрээтэй бөгөөд ихэвчлэн нийгмийн даатгал, нийгмийн халамжаас бүрддэг.¹⁶ Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихэд хадгалагдан үлдсэн төрийн нийгмийн хамгааллын энэхүү сүлжээ нь одоо хүртэл ихээхэн үүрэгтэй байна. Энэ дэд хэсэгт нийгмийн хамгааллын албан болон албан бус (хувийн) хэлбэрүүд, өрхийн хүлээн авч

байгаа хувийн болон улсаас өгч байгаа мөнгөн шилжүүлэг (тэтгэвэр, тэтгэмж, бэлэн мөнгө), тусламжийн талаар дэлгэрэнгүй тайлбарлана.

2.7.1 Мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламжийн хэмжээ, түүний ач холбогдол

Хүснэгт 2.17-д өрхүүдийг мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламжийг хүлээн авч байгаагаар нь ангилан үзүүлэв. Нийгмийн хамгааллын албан болон албан бус сүлжээ нь нэлээд өргөн хүрээг хамарч байгаа бөгөөд бараг бүх өрх ямар нэгэн байдлаар улсаас болон бусдаас мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж авсан байна. Улсаас болон хувь хүнээс бэлэг, тусламж, шилжүүлэг авсан өрхүүдийн хамрагдалт эрс өөр байна. Нийт өрхийн 89.4 хувь нь улсаас шилжүүлэг, халамж, тусламж авсан байхад гэр бүл, найз нөхдөөсөө 19.2 хувь нь л бэлэг, тусламж авчээ. Улсын мөнгөн шилжүүлэг нь нийт шилжүүлгийн 78.8 хувийг бүрдүүлж байна. Улсын мөнгөн шилжүүлгийн гол бүрэлдэхүүн хэсэг нь өндөр насны тэтгэвэр байна. Өндөр насны тэтгэврийг нийт өрхийн 27.1 хувь нь авч байгаа бөгөөд нийт дүнгээрээ улсын мөнгөн шилжүүлгийн 46.7 хувийг бүрдүүлж байна. Өрхийн хувь хүнээс хүлээн авсан нийт шилжүүлгийн дийлэнх нь буюу 17.4 хувь нь гэр бүл, найз нөхдөөс нь ирсэн байна. Улсаас өгч байгаа мөнгөн шилжүүлэг, халамж, тусламжийн хэмжээ тухайн өрхүүдийн хэрэглээний 24.7 хувийг, харин хувиас авч байгаа хэмжээ нь 23.5 хувийг бүрдүүлж байна.

16. Нийгмийн даатгал нь зарим эрсдлийг хамгаалахын тулд улсаас төлж байгаа өндөр настны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, эрүүл мэндийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал гэх мэт мөнгөн тусламж байна. Нийгмийн халамж нь эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардагдаж байгаа бүлэг хүмүүст зориулсан улсаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа байна.

Хүснэгт 2.17. Өрхийн хүлээн авсан шилжүүлэг, бэлэг, тусламж

	Шилжүүлэг бүхий өрхүүд (%)		Шилжүүлэг бүхий хүн ам (%)		Шилжүүлэг хүлээн авч байгаагаас		
	Шилжүүлэг бүхий өрхүүд (%)	Шилжүүлэг бүхий хүн ам (%)	Өрхийн авсан дундаж шилжүүлэг (сард, төгрөгөөр)	Хэрэглээнд эзлэх хувь (%)	Нийт шилжүүлгэнд эзлэх хувь (%)	Өрхийн авсан дундаж шилжүүлэг (сард, төгрөгөөр)	Хэрэглээнд эзлэх хувь (%)
Нийт	89.4	94.1	203 758	29.3	100.0		
Нийгмийн хамгаалал, халамж							
Өндөр насны	87.6	93.2	163 736	24.7	78.8		
Жирэмсний болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн	27.1	23.2	314 181	50.6	46.7		
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний	8.7	11.5	28 120	3.4	1.3		
Тэжээгчээ алдсан хүүхдийн	11.8	13.1	161 938	26.4	10.5		
Хүний хөгжил сангийн	2.2	2.4	145 979	21.5	1.7		
Бусад а/	62.6	76.5	37 289	4.7	12.8		
Бэлэг, тусламж	27.4	31.2	37 988	4.3	5.7		
Гэр бүл, найз нөхдөөс	19.2	17.5	201 772	23.5	21.2		
Бусад б/	17.4	15.6	204 931	24.2	19.6		
Гадаадаас	2.2	2.4	136 131	13.9	1.7		
Дотоодоос	1.7	1.5	353 025	31.8	3.3		
	17.6	16.2	185 226	22.5	17.9		

а/ Нөхөн олговор, ажилгүйдлийн тэтгэмж, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж, олон хүүхэд төрүүлж өстөсөн эхийн урамшуулал, суралцагчдын тэтгэлэг, тэтгэмж болон бусад тэтгэвэр, тэтгэмжүүд орно.
 б/ Төр, улсын болон хувийн компани, байгууллагууд, ТББ-ууд, гадаадын байгууллага, хувь хүний болон бусад эх үүсвэр орно.
 Эх сурвалж: ӨНЭЭС 2014.

2.7.2 Өрхийн хүлээн авч байгаа мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж

Нийгмийн хамгааллын үндсэн зорилгын нэг нь эмзэг бүлгийнхэнд туслах, эдийн засаг, нийгмийн учирч болох сөрөг нөлөөллийг багасгахад оршдог. Хүснэгт 2.18-д ядуурлын түвшин болон зарим нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд улсын, хувийн мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламжийг хүлээн авч байгаа болон аваагүй өрхүүдийн хоорондын хамаарлыг үзүүлэв.

Хувийн мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж авч байгаа хүн амын ядуурлын түвшин хувийн мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж аваагүй хүн амын ядуурлын түвшнээс бага

байна. Энэ дүр зураг хөдөөд илүү их ажиглагдаж байна.

Улсаас мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж авч байгаа болон авахгүй байгаа хүн амын бүлгүүдийн харьцуулалтыг маш болгоомжтой хийх хэрэгтэй. Улсаас мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж авч байгаа хүн амын ядуурлын түвшин аваагүй хүн амын ядуурлын түвшнээс бага, харин улсаас мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж авч байгаа хөдөөгийн хүн амын ядуурлын түвшин хотынхоос өндөр байна. Гэхдээ бараг бүх хүн ам ямар нэг хэлбэрийн мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламжийг улсаас авч байгаа баримт нь дээрх цогц үзүүлэлтүүдийн гаргаж ирж байгаа мэдээллийн ач холбогдолд сөргөөр нөлөөлж болох юм.

Хүснэгт 2.18. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын болон хувийн шилжүүлэг, бэлэг тусламжаар

	Хувийн				Улсын			
	Хот		Хөдөө		Хот		Хөдөө	
	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм
Ядуурлын хамралтын хүрээ	19.3 (1.0)	16.6 (1.3)	25.8 (1.0)	29.5 (1.9)	5.1 (0.9)	19.9 (0.9)	5.4 (1.1)	27.7 (1.0)
Ядуурлын гүнзгийрэлт	5.0 (0.3)	4.4 (0.5)	5.6 (0.3)	7.1 (0.7)	1.1 (0.2)	5.2 (0.3)	0.8 (0.2)	6.2 (0.3)
Ядуурлын мэдрэмж	1.9 (0.2)	1.7 (0.2)	1.9 (0.1)	2.6 (0.3)	0.4 (0.1)	2.0 (0.1)	0.2 (0.1)	2.1 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:								
Хүн амын хувийн жин (%)	81.4	18.6	84.4	15.6	7.2	92.8	6.0	94.0
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	83.6	16.4	82.6	17.4	1.9	98.1	1.2	98.8
Өрхийн ам бүлийн тоо	3.6	3.2	3.6	3.3	2.0	3.7	1.8	3.8
Хүн ам зүйн ачаалал (%)	37.2	47.2	40.9	43.0	2.1	44.6	1.7	46.6
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	25.1	22.7	26.3	25.2	0.7	28.0	0.5	29.6
Өрхийн тэргүүлэгчийн нас	44.7	47.8	45.1	45.8	41.9	45.8	42.4	45.6
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	77.8	58.9	84.2	74.8	69.1	74.5	85.5	82.2

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014

2.7.3 Өндөр насны тэтгэвэр

Хүн амын амьжиргаанд улсаас өгч байгаа мөнгөн шилжүүлэг, тусламж чухал ач холбогдолтой гэж үзээд түүний томоохон бүрэлдэхүүн хэсэг болох өндөр насны тэтгэвэр болон ядуурлын хоорондын хамаарлыг судалж үзэв. (Хүснэгт 2.19) Улсын хэмжээнд тэтгэвэр авагчтай өрхийн амьжиргаа нь тэтгэвэр авдаггүй өрхүүдийнхтэй харьцуулахад илүү сайн байна.¹⁷ Суурьшлаар авч үзэхэд тэтгэвэр авагчтай хөдөөгийн өрхийн ядууралд өртсөн байдал нь тэтгэвэр авагчгүй өрхтэй харьцуулахад харьцангуй доогуур байхад хот суурин газрын тэтгэвэр авагчтай болон авагчгүй өрхүүдийн ядуурлын түвшин ойролцоо байна.

Энэ нь улирлын онцлогоос үл хамаарсан, тогтмол орлогын эх үүсвэр болох тэтгэвэр авагч гишүүнтэй байх нь сумын төв болон хөдөө нутагт байгаа өрхийн амьжиргааг сайжруулж байж болох юм. Улсын дунджаар ядуу хүн амын 17.5 хувь нь тэтгэвэр авагчтай өрхийнх байгаа бөгөөд энэ хандлага хотод өндөр, хөдөөд бага байна. Хүн ам зүйн үзүүлэлтүүд ч гэсэн маш тодорхой хандлагуудыг харуулж байна. Тэтгэвэр авагчтай өрхөд хүүхдийн тоо улсын дунджаар цөөн байгаа хэдий ч хүн ам зүйн ачаалал өндөр буюу өндөр настай хүн амын тоо олон байдаг хандлага хэвээр байна. Эдгээр өрхийн тэргүүлэгчийн дундаж нас нь нэлээд ахимаг, голдуу эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 2.19. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өндөр насны тэтгэвэр

	Улсын дундаж		Хөдөө		Хот	
	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм
Ядуурлын хамралтын хүрээ	23.2 (0.7)	16.3 (0.9)	19.6 (1.0)	16.8 (1.2)	28.9 (1.1)	15.0 (1.3)
Ядуурлын гүнзгийрэлт	5.7 (0.2)	3.7 (0.3)	5.2 (0.3)	4.0 (0.4)	6.5 (0.3)	2.7 (0.3)
Ядуурлын мэдрэмж	2.1 (0.1)	1.3 (0.1)	2.0 (0.1)	1.5 (0.2)	2.3 (0.2)	0.8 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	76.8	23.2	74.0	26.0	81.8	18.2
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	82.5	17.5	76.8	23.2	89.6	10.4
Өрхийн ам бүлийн тоо	3.7	3.0	3.6	3.2	3.8	2.6
Хүн ам зүйн ачаалал (%)	31.2	63.6	30.4	61.6	32.7	67.5
Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин)	30.7	10.2	29.7	11.7	32.3	7.3
Өрхийн тэргүүлэгчийн нас	39.4	61.2	39.3	60.6	39.6	62.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	82.8	61.4	79.2	60.5	88.9	63.3

Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх сурвалж: ӨНЭЭС 2014

17. Өндөр насны тэтгэвэр нь нийгмийн халамжийн нэг хэлбэр бус харин ажилчид тэтгэврийн санд хуримтлуулсан мөнгөнөөсөө авч байгаа юм гэдгийг мартаж болохгүй.



ХАВСРАЛТ А.

ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН 2014 ОНЫ СУДАЛГАА

Энэ хавсралтанд 2014 онд хийгдсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны ерөнхий танилцуулга, түүврийн зохиомж, мэдээллийн чанарын талаарх зарим нарийвчилсан үнэлгээг хийж тусгав.

А.1 ӨНЭЗС-ны талаарх товч танилцуулга

ӨНЭЗС нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индекс ашигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай хэрэглээний мэдээлэл гаргах зорилготой улсын хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм. ҮСХ нь амьжиргааны түвшинг тодорхойлоход шаардлагатай үзүүлэлтүүдийг урьд нь тасралтгүй явагддаг байсан ӨОЗС-нд нэгтгэн 2007 оноос эхлэн ӨНЭЗС нэртэйгээр явуулж буй бөгөөд судалгааны үзэл баримтлалын дагуу хураангуй болон дэлгэрэнгүй гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулан явуулж байна. ӨНЭЗС-г тогтмол явуулж байгаа бөгөөд нэг жилийн хугацааг хамруулан дүн шинжилгээ хийж байна. Энэхүү тайланд 2014 оны 1-р сараас 12-р сарыг дуусталх бүтэн 12 сарын хугацааг хамруулав.

Судалгааны асуулга

2014 оны судалгааг дэлгэрэнгүй хэлбэрээр явуулсан бөгөөд дараах 14 модультайгаар асуулгын маягтаа боловсруулсан. Судалгаанд гурван төрлийн асуулгын хуудас ашигласан. Үүнд:

- Өрхийн нийгэм, эдийн засгийн үндсэн мэдээллийн маягт (ӨНЭЗС-1): ӨНЭЗС-1 маягтаар өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл, боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, мал аж ахуй ба газар тариалан, өрхийн хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ болон бусад орлого, хадгаламж, зээл, орон сууц ба эрчим хүч, удаан эдэлгээт бараа, хүнсний бус зарлагын мэдээлэл цуглуулсан.
- Өрхийн хүнсний мэдээллийн маягт (ӨНЭЗС-2а, ӨНЭЗС-2б): ӨНЭЗС-2а

маягтаар нийслэл, аймгийн төвийн өрхүүдийн өдрийн тэмдэглэлийн нэгтгэл болох гурван арав хоногийн хүнсний хэрэглээний мэдээлэл цуглуулсан. ӨНЭЗС-2б маягтаар сумын төв, хөдөөгийн өрхүүдийн сүүлийн 7 хоногийн хүнсний хэрэглээний мэдээлэл цуглуулсан.

- Өдрийн тэмдэглэлийн маягт (ӨНЭЗС-3): Өдрийн тэмдэглэлээр нийслэл, аймгийн төвийн өрхүүдийн өдөр тутмын хүнсний хэрэглээний мэдээллийг сарын турш цуглуулсан.

А.2 Түүвэрлэлтийн зохиомж

Судалгаанд 2013 оны засаг, захиргааны бүртгэлд үндэслэн ҮСХ-ноос боловсруулсан түүврийн хүрээг ашигласан. Судалгааны түүврийн зохиомжид хот (Улаанбаатар, аймгийн төв), хөдөө (сумын төв, хөдөө нутаг) гэсэн бүлгийг ашигласан. Түүврийн анхан шатны нэгж (ТАШН) нь Улаанбаатарт хэсэг, аймгийн төв болон хөдөөд баг бөгөөд нийт 1800 ТАШН-ийг бүтэн жилийн туршид хамруулсан. Түүврийн хуваарилалтыг хийхдээ аймгуудын үр дүнг хооронд нь харьцуулагдахуйц байлгахын тулд тэгш хуваарилалтын аргаар хийж, ТАШН-ийг 2 шатат энгийн санамсаргүй аргаар сонгосон.

Улаанбаатар хотод 360 ТАШН, аймаг бүрээс 24 ТАШН (Дархан-Уул аймагт 36 ТАШН, Орхон аймагт 60 ТАШН, Говьсүмбэрт 12 ТАШН), харин хөдөөд 48 ТАШН (Дархан-Уул аймагт 24, Орхон аймагт 0, Говьсүмбэрт 12 ТАШН) түүвэрлэн авсан ба Улаанбаатар хот болон аймгийн төвийн ТАШН тус бүрээс 10 өрхийг, хөдөөгийн ТАШН тус бүрээс 8 өрхийг сонгосон.

16200 өрхөөс 3600-г Улаанбаатар хотод, 5400-г аймгийн төвүүдэд, 7200-г сумын төвүүд болон хөдөө нутагт хуваариллаа. Гэхдээ энэ тайланд

ашигласан бодит түүвэр нь үүнээс арай бага буюу Улаанбаатар хотод 3581 өрх, аймгийн төвд 5400 өрх, сумын төв болон хөдөө нутагт 7193 өрх байлаа.

Бүлэг тус бүрт болон улсын хэмжээнд төлөөлөх чадвартай үр дүн гаргахын тулд түүврийн жинг ашигласан болно.

Хүснэгт А.1. 2014 оны ӨНЭЗС-ны түүвэр, ТАШН-ээр, ярилцлага авсан сараар

	Улаанбаатар	Аймгийн төв	Хөдөө	Улсын хэмжээнд
2014 он				
1 сар	300	450	599	1,349
2 сар	300	450	600	1,350
3 сар	300	450	600	1,350
4 сар	298	450	600	1,348
5 сар	297	450	598	1,345
6 сар	298	450	600	1,348
7 сар	298	450	600	1,348
8 сар	300	450	600	1,350
9 сар	300	450	596	1,346
10 сар	298	450	600	1,348
11 сар	300	450	600	1,350
12 сар	292	450	600	1,342
Нийт	3,581	5,400	7,193	16,174

А.3 Мэдээллийн чанар, боловсруулалт

Энэ удаагийн судалгаанд цаасан технологийг бүрэн автоматжуулж, орчин үеийн дэвшилтэт технологи болох таблет төхөөрөмжийг ашигласнаараа өмнөх судалгаануудаас онцлог боллоо. Ингэснээр мэдээллийг анхан шатны нэгжээс нь цуглуулсан даруй төв сүлжээнд дамжуулж, мэдээллийн чанар, аюулгүй байдлыг хангах, хугацаа, хүн хүч болон зардал хэмнэх зэрэг олон давуу талыг бий болгосон юм. Судлаач нарын анхан шатнаас цуглуулсан мэдээлэл эхлээд багийн ахлагчийн түвшинд нэгтгэгдэж хянагдсаны дараа ҮСХ-ны төв сүлжээнд илгээгдэж байсан. Ирүүлсэн мэдээлэлд ҮСХ-ны судалгааны багынхан хяналт тавьж, нэгтгэн мэдээллийн уялдаа, холбооны шалгалтыг хийж, нэмэлт тодруулгыг багийн ахлагчаар дамжуулж, анхан шатнаас авч байлаа. Эдгээр тохиолдолд тодруулгын жагсаалтуудыг өрхүүд дээр

дахин очих, утсаар эргэн тодруулах байдлаар шалгасан бөгөөд алдаа илэрсэн даруйд шууд залруулж байлаа. Үндсэндээ мэдээллийн шалгалтыг гурван үе шатанд буюу таблетанд мэдээлэл оруулах үед, анхдагч тоо мэдээллийг боловсруулах үед, гуравдугаарт, энэ тайланг бэлдэх үед гүйцэтгэсэн. Мөн судалгааг эхлүүлэхийн өмнө таблет төхөөрөмжийн туршилтын судалгааг зохион байгуулсаны зэрэгцээ судалгааны ахлагч, судлаач нарт судалгааг нэгдсэн ойлголт, арга, аргачлалаар цуглуулах талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, судалгааг амжилттай явуулах бэлтгэл ажлыг хангасан. Ингэснээр судалгааны мэдээллийн чанарын стандарт сайн хангагдсан гэж үзэж байна. Судалгааны мэдээллийг CPro 5.0 програм ашиглан цахим санд оруулж, үр дүнг боловсруулж, дүн шинжилгээ хийхэд STATA 12.1 програм ашиглав.



ХАВСРАЛТ Б.

ЯДУУРЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Ядуурлын дүн шинжилгээ хийхэд юуны өмнө 3 бүрэлдэхүүн хэсэг шаардлагатай байдаг. Үүнд: Нэгдүгээрт: хэмжигдэж, хүлээн зөвшөөрөгдөж болохуйц, хүн амыг эрэмбэлэх боломжтой аж байдлын үзүүлэлтүүд; Хоёрдугаарт: хүн амыг ядуу ба ядуу бусаар ангилах сонгогдсон үзүүлэлттэй харьцуулахад тохиромжтой ядуурлын шугам; Гуравдугаарт: аж байдлын бие даасан үзүүлэлтүүдийг нэгтгэн ядуурлын ерөнхий дүр төрхийг харуулах цогц хэмжүүрүүд.

Энэ хавсралтанд ядуурлын хэмжүүр үзүүлэлтүүд, ядуурлын шугамыг тогтоосон байдал, хэрэглээний хэмжээг тодорхойлон бүрдүүлэх боловсруулалтын бүх шатыг тайлбарлана. I бүлэгт хэрэглээг аж байдлын үзүүлэлт болгон сонгон авсан талаар өгүүлнэ. II бүлэгт өрхийн нэрлэсэн хэрэглээг тооцох аргыг харуулна. III, IV бүлэгт өрхийн суурьшил, судалгаанд хамрагдсан он, сар, өдөр болон ам бүлийн бүтцийг засварласнаар бодит хэрэглээний хэмжигдэхүүнийг хэрхэн тооцсон талаар тайлбарлах болно. III бүлэгт газар зүйн байрлалын болон цаг хугацааны үнийн засварлалт, IV бүлэгт өрхийн хүн амын бүтцийн засварлалт, V бүлэгт ядуурлын шугамыг тодорхойлсон аргачлалыг нарийвчлан харуулна. Сүүлчийн VI бүлэгт энэхүү тайланд хэрэглэсэн ядуурлын хэмжүүрүүдийг тайлбарлав.

Б.1 Аж байдлын үзүүлэлтийн сонголт

Ядуурал нь хувь хүний аж байдлын доройтол, хомсдолтой байдлаар илрэх бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавхи доройтох, хоол тэжээлийн хомсдол, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байх зэргээр илэрдэг. Энэ бүгд нь тус бүрдээ аж байдлыг тодорхойлох бүрэлдэхүүн хэсгийг илэрхийлэх тул нэг бүрчлэн анхаарч судлах шаардлагатай бөгөөд бодлого боловсруулагч нарыг ядуурлын олон янзын хэлбэрт анхаарлаа хандуулахад тус болдог. Ядуурлын эдгээр ялгаатай бүрэлдэхүүн хэсгүүд хосолсон байх тохиолдол элбэг байдаг. Жишээлбэл, хоол тэжээлийн дутагдалд үргэлж орсон хүн голдуу боловсрол багатай, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй байх г.м.

Орлого, хэрэглээ хоёрын алиныг нь аж байдлын хэмжүүр үзүүлэлт болгож сонгож авахыг шийдэх нь юуны түрүүнд чухал юм. Хэрэглээ нь амьжиргааны түвшнийг орлогоос арай нарийн хэмжиж тодорхойлдог илүү ач холбогдолтой буюу зохимжтой үзүүлэлт болно. Онолын хувьд ч мөн практик дээр ч амьжиргааны түвшнийг хэрэглээгээр тодорхойлох нь орлогоор тодорхойлсноос илүү зохимжтой, бодит байдлыг илэрхийлдэг гэж үздэг.¹⁸

Хэдийгээр энэ хоёр нь өөр ойлголтууд боловч хоёул сэтгэл ханамжийг ямар нэг байдлаар илэрхийлдгээрээ төстэй. Хэрэглээ нь

хувь хүн бүр бодитоор юу хэрэглэснийг илэрхийлдэг бол орлого нь тухайн хүний чадварыг хөрөнгийн хамт хэмжинэ. Хүний бүхий л амьдралын турш дахь амьжиргааны түвшинг судлахыг сонирхож байгаа бол орлого ба хэрэглээний алийг нь сонгох нь ялгаагүй. Харин богино хугацааны буюу жишээ нь нэг жилийн хувьд орлогоос хэрэглээ нь илүү тогтвортой, өөрчлөлт багатай байна. Мөн түүнчлэн хэрэглээ нь орлоготой харьцуулахад улирлын хэлбэлзэл багатай байдаг. Тухайлбал газар тариалан эрхэлж байгаа өрхийн орлогын түвшин нь ургац хураалт, тариалалтын үетэй холбоотойгоор маш хэлбэлзэлтэй байдаг учраас энэ үзүүлэлтийг ашигласнаар амьжиргааны түвшинг үлэмж хэмжээгээр ихэсгэж, багасгаж бодитой бусаар тооцоолох магадлал илүү байна.

Практик талаас анхаарч үзвэл зохих асуудлууд байдаг. Үүнд юуны өмнө асуулга авахад мэдээлэл өгөгчид ойлгомжтой, хялбар, тодорхой байх шаардлагатай. Хэрэглээ нь мэдээлэл өгөгчдөд орлогоос илүү хялбар ойлголт байдаг. Ялангуяа орлого нь хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанаас орж байгаа тохиолдолд хэрэглээг мэдээлэхэд илүү хялбар байна. Жишээлбэл, албан ёсны бүртгэлтэй салбарт ажиллаж байгаа хүн орлогын үндсэн эх үүсвэрээ буюу жишээлбэл цалин, хөлсөө тодорхой мэдээлэхэд ямар нэг хүндрэл учрахгүй. Харин албан бус сектор, эсвэл хөдөө аж ахуйд ажилладаг, хувиараа хөдөлмөр эрхлэгчид орлогоо нарийн тодорхойлоход бэрхшээлтэй байдаг бөгөөд өрхийн болон бизнесийн ажил гүйлгээ холилдон бүртгэгддэг. Өрхүүд орлогоосоо илүүгээр хэрэглээгээ мэдээлэхдээ дуртай байдаг. Тэд

18. Деатон, Зайди нарын илтгэл (2002)

орлогын талаарх мэдээллийг нь өөр зорилгоор, тухайлбал татварын түвшинг тодорхойлох үүднээс цуглуулж магадгүй гэж болгоомжилдог, эсвэл орлогын талаар асуух нь таатай бус гэж үздэгтэй ч холбоотой юм. Мөн өрхийн гишүүд нь өрхийн орлого, түүний эх үүсвэрээс илүүтэйгээр хэрэглээгээ сайн мэдэж байдаг.

Б.2 Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоох нь

Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоохдоо онол, практикийн үүднээс мөн авч үздэг. Нэгдүгээрт, байгаа мэдээллийг ашиглан аль болох дэлгэрэнгүй байх, хүн амын аж байдлыг тодорхойлохгүй, эрэмбэлэхэд нөлөө үзүүлэхгүй, мэдээллийн зарим нэг хэсгийг тооцоонд оруулахгүй байх ёстой. Хоёрдугаарт, худалдан авалт нь энэ үзүүлэлтийн цорын ганц бүрэлдэхүүн хэсэг биш учир зах зээлийн болон зах зээлийн бус гүйлгээг хоёуланг нь хамруулна. Гуравдугаарт, зардал бол хэрэглээ биш. Удаан хадгалахад тохиромжгүй, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний хувьд худалдан авсанаа бүгдийг нь хэрэглэдэг гэж үзэх нь түгээмэл байдаг. Харин орон сууц, удаан эдэлгээт бараа гэх мэт бусад бараа, үйлчилгээний хувьд тохируулга хийх шаардлагатай. Эцэст нь хэрэглээ нь хүнс, хүнсний бус, сууц, удаан эдэлгээт бараа, эрчим хүч гэсэн 5 үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг бүр тодорхой нэр төрлүүдээс бүрдэх ба эдгээр нэр төрөл бүрийн хэрэглээний үнэлгээг хийх аргачлалыг доор товч тайлбарлав.

Хүнсний бүрэлдэхүүн хэсэг

Хүнсний хэрэглээг тооцохдоо хүнсний бүх бүтээгдэхүүний нэртөрөл тус бүрийн хэрэглээг нэгдсэн нэг цаг хугацаанд шилжүүлэн, нэмж бүрдүүлэх бөгөөд дараа нь өрх бүрийн бүх хүнсний барааг нэгтгэдэг. 2014 оны ӨНЭЗС-гаар гурил, гурилан бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, загас болон далайн бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, төрөл бүрийн өөх тос, жимс, жимсгэнэ, чихэр, жимсний чанамал, хүнсний бусад бүтээгдэхүүн, цай, кофе, цэвэр ус ундаа, жимсний шүүс, согтууруулах ундаа, тамхи гэсэн 13 бүлэг болгон ангилсан 123 нэр төрлийн бүтээгдэхүүний хүнсний хэрэглээний мэдээллийг өрхийн түвшинд цуглуулсан.

Мэдээлэл цуглуулах арга болон хугацаа нь хот, хөдөөд ялгаатай. Хотын суурьшил буюу Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд хүнсний хэрэглээний мэдээллийг өрхийн өдөр тутмын бүртгэл дээр үндэслэн цуглуулсан бөгөөд судлаач нар сард гурван удаа өөрөөр хэлбэл арав хоног бүрт очиж мэдээллийг нэгтгэж байв. Өөрөөр хэлбэл өрх тус бүрийн хувьд хүнсний мэдээллийн хамрах хугацаа нь нэг сар байлаа. Сумын төв болон хөдөөд өрхийн сүүлийн долоо хоногийн хүнсний хэрэглээг эргэн сануулж бүртгэх аргыг ашигласан. Ийм хоёр өөр арга хэрэглэсэн нь дараах гурван шалтгаантай болно. Нэгдүгээрт, судлаач нар аймгийн төвд байрладаг тул аймгийн төвөөс алслагдсан сумын төв болон хөдөөгийн өрхүүдэд арав хоног бүр очих боломж байхгүй. Хоёрдугаарт, малчин өрхүүд тогтмол нүүдэллэдэг учраас хоёр дахь, гурав дахь очилтоор зорьсон өрхөө

олоход хүндрэл учрах магадлал их. Гуравдугаарт, хөдөөгийн хүн ам нь хотын хүн амтай харьцуулахад худалдан авалтыг бөөнөөр нь голдуу хийдэг тул өрхийн өдөр тутмын бүртгэлээ нөхөхөд илүү бэрхшээлтэй байдаг.

Хэрэглээний энэ бүрэлдэхүүн хэсгийг боловсруулахад хэд хэдэн үндсэн зарчмыг хэрэглэсэн. Нэгдүгээрт, хэрэглээний бүх боломжит эх үүсвэрийг оруулав. Өөрөөр хэлбэл хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ нь зах зээлээс худалдан авсан эсвэл гэрээс гадуур хэрэглэсэн хүнсний зүйлээс гадна өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн, бусдаас авсан, бэлэг, бараа солилцоогоор авсан бүтээгдэхүүн зэргээс бүрдэнэ. Хоёрдугаарт, худалдан авсан болон өөрийн аж ахуйгаас авсан бүх хүнсний бүтээгдэхүүнийг биш тухайн хугацаанд хэрэглэсэн бүтээгдэхүүнүүдийг л хэрэглээний бүтцэд багтаасан. Гуравдугаарт, мөнгөөр худалдан аваагүй хүнсний зүйлийг үнэлж аж байдлын хэмжигдэхүүнд оруулсан. ӨНЭЗС-гаар зөвхөн өрхийн хүнсний худалдан авалтын хувьд дундаж үнийн дүн, тоо хэмжээний талаар мэдээлэл цуглуулсан бөгөөд бусад эх үүсвэрийн хувьд зөвхөн тоо, хэмжээний мэдээллийг авсан. Тиймээс худалдан аваагүй хүнсний бүтээгдэхүүний мөнгөн дүнг тооцохдоо дундаж үнийн мэдээллийг ашиглалаа.

Ихэнх хүнсний бүтээгдэхүүнүүд харгалзах бүлэг дотроо нэлээд дэлгэрэнгүй нэр төрлөөр орсон учир нэр төрөл тус бүр нь харьцангуй нэгэн жигд болсон. Гэхдээ нэгжийн үнэ нь бодит үнэ биш боловч барааны чанарын ялгааг илэрхийлнэ. Энэ нөлөөллийг багасгаж, газар зүйн байрлалын болон цаг хугацааны

зөрүүг авч үзэхийн тулд хэд хэдэн түвшинд (өрх, түүврийн нэгж, аймаг, суурьшил, улирал) үнийн медиан утгыг тооцсон болно. Иймээс тухайн өрх хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бол уг худалдан авсан барааны харгалзах медиан үнийг өөрийн аж ахуйн болон солилцоогоор авсан барааг үнэлэхэд ашиглана. Хэрвээ өрх ямарваа нэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг огт худалдан аваагүй боловч хэрэглэсэн бол хэрэглээг нь үнэлэхэд түүний дээд түвшний (өрхийн харьяалагдах түүврийн нэгжийн гэх мэт) үнийг ашиглана. 2014 оны хүнсний хэрэглээний бүтцэд худалдан авсан, бусдаас үнэгүй авсан болон өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн тоо хэмжээг авч үзсэн.

Хүнсний бус бүрэлдэхүүн хэсэг

Хүнсний бус хэрэглээг хүнсний хэрэглээтэй адилаар шууд, хялбархан тооцоолно. Хүнсний хэрэглээтэй адилаар нэгдсэн нэг хугацаанд шилжүүлэн тэгшитгэсэн хэрэглээний бүхий л эх үүсвэрийг оруулах ёстой. Хүнсний бус хэрэглээгээр өргөн хүрээний буюу эрэгтэй, эмэгтэй хүний, хүүхдийн хувцас, гутал, бэлэг дурсгал, үнэт эдлэл, бөс бараа, боловсрол, эрүүл мэнд, амралт чөлөөт цаг, соёлын зардал, гоо сайхан, ариун цэврийн бараа үйлчилгээ, гэр ахуйн бараа, удаан эдэлгээт бараа, орон сууцны зардал, тээвэр, холбоо, даатгал, татвар зэрэг 38 бүлгийн 371 нэр төрлийн бүтээгдэхүүний мэдээллийг цуглуулсан. Хүнсний бус барааны ихэнх нэр төрөл нь дотроо ижил бус буюу зарим ялгаатай олон бүтээгдэхүүнийг агуулж нэгжийн үнийг нь тооцоход бэрхшээлтэй байдаг тул ӨНЭЗС-гаар энэ бүлгийн барааны

тоо хэмжээний талаарх мэдээллийг цуглуулдаггүй. Удаан эдэлгээт бараа, сууц, түлш, эрчим хүчнээс бусад хүнсний бус барааны хэрэглээг энэ бүлэгт авч үзнэ.

Хэрэглээг бүрдүүлэхэд мөн тухайн нэр төрлийг оруулах эсэх, судалгааны үеийг тодорхойлох гэсэн үндсэн 2 бэрхшээл байдаг. Нэгдүгээрт, зөвхөн хэрэглээнд ордог нэр төрлүүдийг л судалгаанд багтаах ёстой гэсэн алтан дүрэм бий. Тухайлбал, хувцас, гутал, гоо сайхны бараа, бүтээгдэхүүн, амралт, чөлөөт цагт зарцуулсан зардал гэх мэт зүйлс хамрагдана. Татвар илүү төлснөөрөө тухайн өрх улсаас илүү их үйлчилгээ авдаггүй нь хэрэглээний өндөр түвшинтэй уялдахгүй байгааг харуулж байна. Иймээс татварын хэмжээг хэрэглээнд оруулахгүй. Хөрөнгийн урсгал буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, өр, зээлийн хүүгийн төлбөрийг мөн оруулдаггүй. Гэнэтийн эсвэл бөөн дүнгээр гэнэт зарцуулагддаг хурим, төрөлт, оршуулгын зардлын хувьд бүр ч бэрхшээлтэй байдаг. Эдгээр зардлыг он жилүүдэд тархаан, тэгшитгэж тооцох нь хамгийн оновчтой хувилбар юм. Харин тэгшитгээгүй тохиолдолд тухайн өрхийн хэрэглээний түвшин бодит хэмжээнээс илүүтэйгээр тооцогдоно. Одоогоор бидэнд ингэж тооцох хангалттай мэдээлэл байхгүй тул эдгээр хэрэглээнүүдийг тооцоонд оруулаагүй болно. Хүлээн авсан бэлэгтэй холбоотой тооцоо нь бэлгийг хүлээн авч байгаа талын тооцоонд тусгагддаг тул, тооцоог давхардуулахгүйн тулд бусдад өгсөн бэлэг, тусламж, шилжүүлгийг тооцоонд оруулаагүй. Хэрэв эдгээрийг тооцоонд оруулбал амьжиргааны дундаж түвшинг хиймлээр өсгөх болно.

Хүнсний бус хэрэглээний бүрэлдэхүүн хэсэг дотроос хоёр зүйл буюу эрүүл мэнд, боловсролын тооцоог онцгойлон авч үзэх шаардлагатай. Нэгдүгээрт, боловсрол нь хэрэглээ биш харин хөрөнгө оруулалт тул хадгаламж гэж үзэх ойлголт байдаг. Боловсролын үр өгөөжийг зөвхөн сурч байх тухайн үедээ бус бүхий л амьдралынхаа турш хүртэнэ. Хоёрдугаарт, хэрэв амьдралын удаан хугацааны үеийг авч үзэж байгаа бол боловсролын зардал нь хүний амьдралын тодорхой үед л гардаг. Сургалтандаа яг ижил хэмжээний зардал зарцуулсан бөгөөд нэг нь одоо суралцаж байгаа нөгөө нь нилээд хэдэн жилийн өмнө сургуулиа төгсчихсөн хоёр хүнийг харьцуулья. Энэ тохиолдолд одоо суралцаж байгаа нь амьжиргаа дээгүүртэй мэт бодогдох боловч энэ үр дүн нь зөвхөн насны хувьд хамаатай бөгөөд жинхэнэ аж байдлын түвшний ялгааг харуулж чадахгүй. Энэ зардлыг амьдралынх нь нийт хугацаанд тэгшитгэн хуваарилах нь хамгийн оновчтой арга болно. Гуравдугаарт, улсын сургуульд суралцах боломжийг авч үзэх хэрэгтэй. Хэрэв бүх хүн үнэ, төлбөргүй эсвэл өндөр татаас бүхий боловсрол эзэмших боломжтой бөгөөд харин чанарыг нь харгалзан үзэж хувийн сургуулийг сонгон төлбөр төлж суралцдаг бол боловсролын зардлын ялгаатай байдал нь аж байдлын ялгаатай байдалтай холбогдох ба ийм тохиолдолд тухайн зардлыг тооцоонд тусгах нь зүйтэй гэж үздэг. Энэ судалгаанд боловсролын зардлыг хэрэглээний бүтцэд оруулсан. Эдгээр зардлыг оруулахгүй байх нь сургуулийн насны хүүхдүүдтэй хоёр өрхийн зөвхөн нэг нь хүүхдээ сургуульд сургах боломжтой бол энэ

ялгааг гаргаж чадахгүйд хүрнэ.

Эрүүл мэндийн зардал ч зарим талаараа боловсролтой адил юм. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт зарцуулсан зардал нь мөн хөрөнгө оруулалттай адилаар тооцогдоно. Төрөөс хангадаг үйлчилгээг харилцан адилгүй хүртдэг тохиолдолд өрх хоорондын харьцуулалтыг хийх нь буруу үр дүнд хүргэнэ. Хүн амын зарим хэсэг нь эмнэлгийн үнэ төлбөргүй, эсвэл улсаас ихэнх зардлыг нь хариуцдаг үйлчилгээнд хамрагдаж байхад нөгөө хэсэг нь хувийн салбарын үйлчилгээнд хамрагдаж байвал зардлын энэ ялгавартай байдал аж байдлын ялгааг харуулахгүй. Энд анхааран үзэх хэд хэдэн зүйл бий. Үүнд: Нэгдүгээрт, эрүүл мэндийн зардал нь байнга бус тодорхой цаг хугацаанд бөөнөөр гардаг. Хоёрдугаарт, эрүүл мэндийн зардал нь өрхийн гишүүн өвчтэй байсантай холбогдон гарсан зардлыг авч үзэж байгаа тохиолдолд өрхийн аж байдал муудах боловч зардал гарсан учир аж байдал нь өссөн мэт харагддаг. Гуравдугаарт, эрүүл мэндийн даатгал нь харьцуулалтыг буруу үр дүнд хүргэдэг. Учир нь өрхийн даатгалтай гишүүн нь өвдөхдөө бага хэмжээний мөнгө зарцуулсан байхад даатгалгүй нь ихийг зарцуулна. Иймээс энэ судалгааны хувьд эрүүл мэндийн зардлыг хүнсний бус хэрэглээний бүрэлдэхүүнд оруулж байна. Эрүүл мэндийн зардлыг хасвал өвчтэй хүнтэй хоёр өрхийн хувьд нэг нь эмчилгээнд мөнгө зарцуулах чадвартай, нөгөө нь чадваргүй байгаа бол энэ өрхүүдийн ялгааг харуулж чадахгүй болно.

Хүнсний бус хэрэглээтэй холбоотой хоёр дахь бэрхшээлтэй асуудал нь хэрэглээг тооцох хугацааг

сонгох юм. Үүнд худалдан авалт хийх давтамж, өрхийн хэрэглээгээ буцаж санах хугацааны хоорондын хамаарал орно. Ариун цэврийн хэрэгсэл, гоо сайхны бараа, орон сууцны төлбөрөөс бусад хүнсний бус олон бараа, бүтээгдэхүүний хувьд долоо хоног, сард ямар нэгэн худалдан авалт гараагүй байдаг тул буцааж санах хугацааг ихэнхдээ сүүлийн улирал эсвэл сүүлийн жилээр сонгодог.

ӨНЭЭС нь сүүлийн сар ба сүүлийн жил гэсэн судалгааны хоёр үеийг хамарсан мэдээлэл цуглуулдаг. Аль үеийг сонгох нь хэрэглээний бүтцэд үлэмж нөлөөтэй байдаг. Өрхүүд сар бүр хүнсний бус бараа, бүтээгдэхүүн худалдан аваад байдаггүй учраас олон өрхийн хувьд ямар ч хэрэглээгээ мэдээлэхгүй байх магадлалтай. Сүүлийн нэг сарын худалдан авалтыг тооцоонд ашигласнаар сарын дундаж хэрэглээг ойролцоогоор тооцоолж болох ч судалгаанд хамрагдсан нэг сарын хугацаанд худалдан авалт хийгээгүй өрхүүдийг хэрэглээ багатайд тооцон улмаар ядуу гэсэн ангилалд хамааруулах магадлалтай юм. Сүүлийн нэг жилийг эргэн санах хугацаа болгон авбал хүнсний бус бараа, бүтээгдэхүүний хувьд илүү үндэслэлтэй хугацаа болох учир дээрх бэрхшээл арилна. Гэвч эргэн санах хугацааг уртасгахаар нэг сул тал үүсдэг. Зарлагаа мэдээлэх өрхийн тоо нь нэмэгдэх боловч дундаж зарлага нь эргэн санах хугацаа богинотой зардлаас багасаж гарч ирдэг. Энэ хоёр сонголтын давуу болон сул талыг нь харгалзаж үзсэн гуравдахь сонголт нь эргэн санах хоёр хугацааг хоёуланг нь хослуулах арга юм. Энэ тохиолдолд хэрэв тухайн өрх сүүлийн нэг сард хүнсний бус бараа, бүтээгдэхүүн худалдан авсан

бол тухайн мэдээллийг нь авч, харин сүүлийн нэг сарын хугацаанд хүнсний бус бараа бүтээгдэхүүн худалдан аваагүй бол сүүлийн нэг жилийнх нь мэдээллээс авдаг.

Удаан эдэлгээтэй бараа

Өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээт бараа нь амьжиргааны түвшнийг тодорхойлох чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Эдгээр бараа нь удаан хугацаанд ашиглагддаг учир худалдан авсан үнэ нь хэрэглээг тодорхойлох тохиромжтой үзүүлэлт болохгүй. Энд тооцоо хийх хамгийн зөв арга нь тухайн хугацаанд эзэмшиж байгаа удаан эдэлгээт бараанаас авч байгаа үйлчилгээний түвшинг тооцоход оршино. Энэхүү авч байгаа ханамжийн хэмжээ нь биетээр ажиглагдахгүй ч үнийн дүнтэй шууд пропорциональ бөгөөд элэгдлийн түвшин гэсэн үзүүлэлтээр тодорхойлогдоно. Бараа бүрийн элэгдлийн түвшинг тооцох үйл ажиллагаа ӨНЭЗС-гаар авсан удаан эдэлгээт барааны одооны зах зээлийн үнэ, ашигласан (мэдээлэл нь өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээт барааны тоо ширхэгийн хамт цуглуулагдсан) хугацаанд үндэслэнэ.¹⁹

Энэ бүрэлдэхүүн хэсгийн тооцоог 3 үе шаттайгаар хийнэ. Нэгдүгээрт, удаан эдэлгээт бараанаас хэрэглээний бүрэлдэхүүнд орох нэр төрлийг сонгоно. ӨНЭЗС-гаар гэр ахуйн хэрэгслээс эхлүүлээд тавилга хүртэлх 44 нэр төрлийн удаан эдэлгээт барааны талаар мэдээлэл цуглуулсан. Гэхдээ нийт удаан эдэлгээт барааны 1/3 болох өрхийн бизнест ашиглагдах бараа эсвэл сууц болон “бусад” гэж

ангилагдсан бараануудыг тооцоонд оруулаагүй. Хоёрдугаарт, хэрэглээний бүрэлдэхүүнд сонгон оруулсан удаан эдэлгээт барааны хувьд элэгдлийн түвшинг тооцохдоо нэгжийн үнэ (хувьсах хэмжигдэхүүн) ба ашигласан хугацаанд үндэслэсэн шугаман регресс тооцсон. Энэхүү тооцооны арга нь нэг барааны хувьд хэрэглэсэн хугацаанаас хамааран элэгдлийн өөр, өөр түвшинг бодох боломжийг олгодог. (Жишээ нь удаан эдэлгээт бараа нь шинэ бол элэгдлийн түвшин буюу бараанаас авч буй ханамж өндөр байна.) Эцэст нь хэрэглээг тооцохдоо тухайн барааны нэг жилийн өмнөх үнийг элэгдлийн хувиар үржүүлэн эдгээр хэрэглээг өрхөөр нэгтгэж гаргана.

Сууц

Хүн амын амьжиргааны түвшний гол үзүүлэлт нь орон сууцны нөхцөл билээ. Хөгжиж байгаа орнуудын хувьд орон сууцны түрээсийн зах зээл хязгаарлагдмал эсвэл байдаггүй учир тооцоо хийх, хэрэглээний бүтцэд оруулахад нэлээд бэрхшээлтэй байдаг. Үүнийг хэрэглээний бүтцэд оруулах зорилго нь удаан эдэлгээт бараатай адилаар тухайн орон сууцыг эзэмшиж байгаагаас авах ханамжийн хэмжээг тооцож оруулахад оршино. Хэрвээ тухайн өрх байр түрээслэн амьдарч байгаа бол төлбөрийн хэмжээ нь энэ ханамжийн үнэлгээ болно. Монгол орны хувьд орон сууц түрээслэн амьдарч байгаа өрхийн тоо цөөн (сүүлийн жилүүдэд нилээд түгээмэл болж байгаа), мөн түрээсийн өртөг хэтэрхий өндөр байдаг учир уг мэдээлэл дээр үндэслэн өөрийн сууцанд амьдарч байгаа өрхийн хувьд сууцнаасаа авч байгаа сэтгэл ханамжийн хэмжээг буюу түрээсийн

19. Инфляцийн түвшин болон нэрлэсэн хүүгийн түвшинг ашиглан улам боловсронгуй болгож болно.

зардлыг тооцох боломжгүй юм. Хэдий тийм боловч ӨНЭЗС-гаар тухайн өрх хэрвээ сууцаа түрээслэвэл хэдэн төгрөгөөр түрээслэх (хийсвэр түрээс) болон орон сууцаа худалдах үнийг нь судалсан. Бодит түрээсийн утга бүртгэгдээгүй тохиолдолд хийсвэр түрээсийн утгыг ашиглан тооцооны түрээс тооцож хэрэглээний иж бүрдэлд оруулж болно. Тооцооны түрээсийн утгыг таамаглаж гаргадаг учраас зарим тохиолдолд ашиглах боломжгүй ч байх талтай. Мөн хүн амын тал орчим хувь нь гэрт амьдардаг тул түрээсийн утгыг тооцоход бүр илүү хүндрэлтэй байна.

Тооцооны түрээсийн утгыг тооцохын тулд сууцны худалдах үнийг хамаарагч хувьсагч болгон сонгож регрессийн шинжилгээ хийсэн. Үл хамаарах хувьсагчдаар орон сууцны нөхцлийг тодорхойлогч шал, хана, дээврийн үндсэн материалын төрөл, өрөөний тоо, усан хангамж, цахилгаан, дулаан, байршил зэргийг авсан. Орон сууцны төрлөөр гэр, сууцны тусдаа байшин, нийтийн тохилог сууцны хувьд уг тооцоог тус тусад нь хийв. Тооцооны үр дүнгээс харахад орон сууцны худалдах үнийн мэдээлэл нь сууцны нөхцөлтэй нягт хамааралтай буюу илүү бодитой байна. Энэ нь тухайн өрх сууц түрээслэдэггүй боловч сууцны үнийн хувьд өөрсдөө барьсан эсвэл худалдаж авсан байдгаас таамагласан хийсвэр түрээсийн үнээс илүү найдвартай дүнг хэлсэн гэж үзнэ.

Гэхдээ сууцны үнийг ашиглаж сууцнаас авч байгаа үйлчилгээний тооцоог гаргахад нэмэлт тооцоо хийх буюу сууцны элэгдлийн түвшинг тодорхойлох шаардлагатай болдог. Сууцны тусдаа байшин болон нийтийн тохилог сууц 33 жилийн дараа, гэр 17 жилийн дараа бүрэн элэгдэнэ гэж

тооцоонд тусгасан болно. Тиймээс хэрэглээний бүтцийг байгуулахдаа бид сууцнаас авч буй үйлчилгээний тооцоонд сууцны үнийг ашиглан бодсон тооцооны хийсвэр түрээсийг оруулсан бөгөөд гэхдээ мэдээж хэрэв бодит түрээсийн мэдээлэл тухайн өрхийн хувьд байгаа тохиолдолд түүнийг нь ашиглана.

Түлш, эрчим хүч

Хүнсний бус хэрэглээний анхааран үзэх бас нэг бүрэлдэхүүн хэсэг нь эрчим хүчний хэрэглээ буюу голлон халаалт, цахилгааны зардал юм. Монголын уур амьсгал өвөрмөц өвөл нь -40, зун нь +30 хэмийн температурт хүрдэг эрс тэс уур амьсгалтай. Хэдийгээр зуны улиралд байгаль цаг уурын нөхцөл харьцангуй тааламжтай хэдий ч өвлийн улирал нь онцгой хүнд нөхцөл үүсгэдэг. Өвлийн улирал бараг 6 сар үргэлжлэн, голдуу хасах градустай байдаг бөгөөд нэг, хоёрдугаар сарын дундаж температур -25 байдаг. Энэ нь орон даяар халаалт болон түлш өрхийн хэрэглээний зайлшгүй, нэн чухал хэрэгцээ болохыг илэрхийлж байгаа бөгөөд зарим тохиолдолд хэрэглээний иж бүрдлийн маш том, чухал бүрэлдэхүүн хэсэг ч болдог.

ӨНЭЗС-гаар худалдан авсан болон өөрсдөө бэлтгэсэн түлш, мөн эрчим хүчний зардлыг өрхүүдээр өөрсдөөр нь үнэлүүлэн мэдээллийг нь цуглуулсан. Өөрсдөө бэлтгэсэн түлшний тоо, хэмжээний талаар ямар ч мэдээлэл байхгүй нөхцөлд хэрэглээний утгыг тооцох боломжгүй болох буюу өрхийн эрчим хүчний хэрэглээ дутуу тооцогдох магадлалтай байдаг. Тиймээс өрх халаалт, гэрэлтүүлэгтээ түлш буюу мод, нүүрс, аргал хэрэглэдэг бол худалдан авалтын

мэдээлэл, харин худалдан аваагүй тохиолдолд өөрсдийн бэлтгэсэн түлшний тоо хэмжээний мэдээллийг нь цуглуулсан учраас хэрэглээг нь бүрэн тооцох боломжтой болсон юм.

Өрхийн өөрсдийн бэлтгэж хэрэглэсэн түлшийг үнэлэхдээ уг өрхийн харгалзах түүврийн нэгж дэх тухайн төрлийн түлшийг худалдан авч хэрэглэсэн өрхүүдийн түлшний нэг нэгжид харгалзах медиан үнийг ашигласан. Хэрэв тухайн түүврийн нэгжид уг нэр төрлийн түлшний худалдан авалт хийгдээгүй бол худалдан авалт хийгдсэн түүний дээд түвшний (сум, аймаг, бүс, суурьшил) түүврийн нэгжид харьяалагдах медиан үнийг ашигласан. Ингээд өрхийн өөрсдийн бэлтгэж хэрэглэсэн түлшний тоо хэмжээг тухайн түвшинд харгалзах медиан үнээр үржүүлж, түлш эрчим хүчний хэрэглээнд оруулсан болно.

Б.3 Үнийн засварлалт

Монголд хүнсний бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл өндөр. Жишээ нь хаврын улиралд хүнсний бүтээгдэхүүний үнэ бусад улирлыг бодвол харьцангуй өндөр болдог бөгөөд бүс нутгуудын хувьд үнэ харилцан адилгүй байдаг. Ялангуяа бусад бүсүүдтэй харьцуулахад Улаанбаатар хотод зарим бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр байдаг. Ийм ч учраас амьжиргааны түвшинг бодитойгоор тооцохын тулд зарлагын дүнг үнийн индексийг ашиглан засварлах шаардлагатай болдог. Үнийн индекс нь үнийн түвшин, хэрэглээний бүтэц хоёроос хамааран хувьсдаг тул үнэ болон үнийн тохирох түвшинд харгалзах нийт зардалд эзлэх тухайн бараа бүтээгдэхүүний

хувь хэмжээ буюу хэрэглээний хувийн жин гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Өрхийн судалгаа нь хэрэглээний бүх нэр төрлийн хувьд нийт зардалд эзлэх тухайн бараа, бүтээгдэхүүний хувь хэмжээг, харин зөвхөн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд өрхөөс зарцуулсан дундаж үнийн мэдээллийг цуглуулдаг. ӨНЭЗС болон улсын хэрэглээний үнийн индексээс авсан мэдээллийг хослуулан ашиглаж түүврийн анхан шатны нэгжийн түвшинд Паашийн үнийн индексийг тооцов. Түүврийн анхан шатны нэгжүүд нь хотод 10 өрхөөс, хөдөөд 8 өрхөөс бүрддэг. Нэг түүврийн анхан шатны нэгжид харьяалагдаж байгаа өрхүүдийн хэрэглэдэг бараа, үйлчилгээний үнэ болон хэрэглээний бүтэц нь ойролцоо байх магадлалтай.

Түүвэрлэлтийн анхан шатны i нэгж дэх Паашийн үнийн индексийг дараах томъёогоор тодорхойлно:

$$p_i^p = \left[\sum_{k=1}^n w_k \left(\frac{p_k}{p_{0k}} \right)^{-1} \right]^{-1}$$

Энд w_k - түүврийн анхан шатны i нэгжийн k нэрийн барааны төсөвт/хэрэглээнд эзлэх хувийн жин;

p_k - түүврийн анхан шатны i нэгжийн k нэрийн барааны дундаж үнэ (үнийн медиан);

p_{0k} - i нэгжийн k нэрийн барааны улсын дундаж үнийн түвшин (үнийн медиан).

Хүнсний хувьд нэр төрөл тус бүрийн нийт хэрэглээнд эзлэх дундаж хувь хэмжээ болон нэгжийн дундаж үнийг хоёуланг нь ӨНЭЗС-аар цуглуулсан. Хүнсний бус бүрэлдэхүүн хэсгийн хувьд төсөвт эзлэх дундаж хувь хэмжээг ӨНЭЗС-наас, харин дундаж үнийг улсын хүнсний бус барааны үнийн мэдээллээс авч ашигласан. Хүнсний бүтээгдэхүүний хувьд цаг хугацааны болон газар зүйн байршлын засварлалтыг, харин хүнсний бус бүх бараа, бүтээгдэхүүний хувьд цаг хугацааны засварлалтыг оруулж тооцсон.

Хүнсний бүтээгдэхүүний дундаж утгууд болон нийт үнийн индексийг сараар болон бүлгээр нь Хүснэгт Б.1-д харуулав. Энэ индексээс амьжиргааны өртөг бусад аль ч нутаг дэвсгэрээс Улаанбаатар хотод илүү өндөр байгааг мөн улирлын нөлөөллийг харж болно. Өөрөөр хэлбэл энэ индекс 1, 2-р улиралд хамгийн өндөр

бусад улиралд арай бага байна.

Б.4 Өрхийн бүтцийн засварлалт

Аж байдлын үзүүлэлтийг бий болгох эцсийн шат нь өрхийн түвшинд тодорхойлогдсон амьжиргааны түвшний хэмжигдэхүүнүүдийг нэг хүнд ногдох хэмжээнд шилжүүлэх явдал бөгөөд зэрэгцүүлэлтийг өрхөөр биш хувь хүнээр хийдэг. Эрүүл мэндийн болон боловсролоос бусад зардлын мэдээллийг өрхийн түвшинд цуглуулдаг тул хувь хүний аж байдлын түвшинг тооцохын тулд өрхийн нийт хэрэглээг тухайн өрхийн нийт ам бүлийн тоонд харьцуулан тооцно. Өрхийн гишүүн бүр ижил хувь, хэмжээтэйгээр хэрэглэнэ гэж үзэх нэгдсэн практикт үндэслэнэ.

Хэрэглээний бүтэц, хэмжээг 2 аргаар засварладаг. Үүний тулд нэгдүгээрт, өрхийн ам бүлийн бүтцийн засварлалтыг хийнэ. Өрхийн

Хүснэгт Б.1. Түүврийн анхан шатны нэгжийн Паашийн индекс, бүлгээр, ярилцлага авсан сараар

	Хүнсний Паашийн индекс				Нийт Паашийн индекс			
	Улаанбаатар	Аймгийн төв	Хөдөө	Улсын дундаж	Улаанбаатар	Аймгийн төв	Хөдөө	Улсын дундаж
2014 он								
1 сар	1.02	0.95	0.93	0.97	0.99	0.95	0.94	0.95
2 сар	1.04	0.95	0.92	0.98	0.99	0.96	0.94	0.96
3 сар	1.08	0.99	0.95	1.01	1.00	0.98	0.95	0.97
4 сар	1.09	1.02	0.89	1.00	1.01	0.99	0.92	0.97
5 сар	1.09	1.03	1.01	1.05	1.02	1.00	1.00	1.00
6 сар	1.07	1.01	0.96	1.02	1.02	1.00	0.97	0.99
7 сар	1.07	0.99	0.87	0.98	1.02	1.00	0.92	0.97
8 сар	1.04	0.96	0.91	0.98	1.04	1.00	0.95	0.99
9 сар	1.05	0.97	0.93	0.99	1.05	1.02	0.98	1.01
10 сар	1.05	0.98	0.95	1.00	1.06	1.03	1.00	1.02
11 сар	1.07	0.99	0.95	1.01	1.07	1.04	1.00	1.03
12 сар	1.08	1.00	0.95	1.01	1.08	1.04	1.00	1.03
Дундаж	1.06	0.99	0.93	1.00	1.03	1.00	0.96	0.99

Эх сурвалж: ӨНЭЗС 2014.

гишүүдийн нас, хүйс, онцлогоос хамааран янз бүрийн хэрэгцээ шаардлагатай байдаг боловч өөр онцлогуудыг бас авч үзэж болно. Жишсэн хүнд шилжүүлэх арга нь эдгээр ялгаатай байдлыг харгалзан өрхийн гишүүдийг “жишсэн насанд хүрсэн” гэж томъёолсон нэг хэмжээст шилжүүлдэг. Жишээ нь: хүүхдийн хэрэглээ насанд хүрсэн хүнийхээс бага гэж үзвэл ам бүлийн тоо, хэрэглээний түвшин нь адилхан 2 өрхийн нэг нь хүүхэдтэй, нөгөө нь зөвхөн насанд хүрсэн хүмүүстэй бол хүүхэдтэй өрхийн нэг хүнд ногдох амьжиргааны түвшин илүү дээр байна.

Хоёр дахь засварлалт нь хэрэглээнд байгаа эдийн засгийн хэмжүүрийг засварлахад оршино. Үүнийг хэрэглэх шалтгаан нь өрхийн хэрэглэсэн зарим бараа, үйлчилгээ “нийтийн буюу дундын бараа” гэсэн онцлогтой байдаг. Өрхийн нэг гишүүний тухайн барааг хэрэглэх нь нөгөө нэг гишүүний хэрэглэх боломжийг хаахгүй бол тухайн барааг нийтийн буюу дундын гэнэ. Эдгээр барааны жишээ бол сууц, удаан эдэлгээт бараа юм. Өрхийн хэрэглээнд эзлэх нийтийн хэрэглээний барааны хувь өндөр байх тусам эдийн засгийн хэмжүүр их байна. Нөгөө талаас хувийн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг өрхийн нэг гишүүн хэрэглэсэн бол нөгөө гишүүн хэрэглэх боломжгүй байдаг. Хүнсний бүтээгдэхүүн нь хувийн хэрэглээний сонгомол жишээ юм. Ядуу эдийн засагтай орны хувьд хүн амын хэрэглээний түвшинд хүнсний эзлэх хувь өндөр байдаг тул эдийн засгийн хэмжүүр бага байдаг. Дээрх 2 төрлийн хэмжүүрийн засварлалтыг доорх аргаар хийнэ.

$$AE = (A + \alpha K)^\theta$$

Энд AE - өрхийн жишсэн ам бүлийн тоо. A – насанд хүрсэн хүний тоо. K - хүүхдийн тоо, α -хүүхдийг насанд хүрэгчтэй харьцуулсан харьцангуй өртгийг хэмжих параметр, θ -эдийн засгийн хэмжүүрийн зэрэг.²⁰

Энэ 2 параметрийн утга нь 0-1 ийн хооронд байна. Хөгжиж байгаа орны хувьд хүүхдийн хэрэглээний түвшин насанд хүрсэн хүнийхтэй харьцуулахад доогуур байдаг учир α – гийн түвшин доогуур ойролцоогоор 0.3 байдаг бол хөгжингүй орны хувьд 1-тэй ойролцоо байдаг.²⁰ Үүний зэрэгцээ ядуу улс орны хувьд хувийн хэрэглээний үндсэн хэсэг болох хүнсний хэрэглээ нь нийт өрхийн хэрэглээний дийлэнх хувийг эзэлдэг учир нийтийн хэрэглээний барааны эзлэх хувь бага, эдийн засгийн хэмжүүр θ нь 1-д дөхөж очдог бол баян орны хувьд 0.75 байдаг.

α болон θ -г ямар утгатайгаар авч тооцоонд ашиглах эсвэл хэрхэн шинээр тооцох, энэ нь тооцоонд хэр тохиромжтой эсэхийг тодорхойлсон нэгдсэн арга, аргачлал одоог хүртэл байхгүй маргаантай хэвээр байна. Тиймээс нэг хүнд шилжүүлэх зохицуулалтыг хийхдээ хүүхдийн хэрэглээ, насанд хүрсэн хүний хэрэглээнээс ялгаагүй, эдийн засгийн хэмжүүр байхгүй гэж үздэг олон улсад хэрэглэгддэг нэгдсэн стандартыг дагав. Энэ нь α болон θ -гийн түвшин аль аль нь нэгтэй тэнцүү гэж үзсэн дээрх томъёоны тухайн тохиолдол юм.

20. Хэрвээ жишсэн хүнд шилжүүлэх мэдрэмж нь “бодит хэмжээс” бол $(A + \alpha K)$ нь θ болно. Эдийн засгийн хэмжүүр нь 1- θ байна. Эдгээр параметрууд нь 0-ээс 1 байна.

